

Монгол Улс дахь гадаадын хөрөнгө оруулалт

З. Манлайбаатар
Б. Мөнх-Ирээдүй
Б. Дэлгэрмаа
Т. Дөлгөөн

Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн (ЭЗСЭШХ)

Хураангуй

юу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсантай холбоотойгоор 2008 онд Монгол дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) нэмэгдэж эхэлсэн. Гэхдээ дэлхий нийтийг хамарсан санхүү эдийн засгийн хямралаас үүдэж 2009 онд энэхүү өсөлт тасалдсан бөгөөд 2010, 2011 онуудад эргээд өндөр өсөлтийг үзүүлсэн. ГШХО-ийн өсөлт нь голчлон уул уурхайн салбарын өсөлттэй холбоотой бөгөөд уул уурхайн салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар богино хугацаанд ГШХО-ыг өсгөх боломжтой. ГШХО-ийн орох урсгалын нэмэгдүүлснээр эдийн засгийн тогтвортой байдал, өсөлтийг нэмэгдүүлнэ.

Энэхүү судалгаагаар ГШХО-ын урсгалд нөлөөгч гол хүчин зүйлийг тодорхойлох, ГШХО-ын эдийн засаг дахь нөлөөг үнэлэх, бусад улсын сайн туршлага дээр тулгуурлаж, ГШХО-ыг хэрхэн татах талаар судлахыг зорилоо. ГШХО-ийн орох урсгалд нөлөөлдөг экзогени ба эндогени хүчин зүйлийг судалснаар хөрөнгө оруулалтын хэлбэлзлийг илүү сайн тайлбарлана. Монголын эдийн засаг дахь ГШХО-ын нөлөөг шинжлэхдээ 2010 болон 2015 оны Орц-Гарцын хүснэгтийн тоон мэдээллийг ашигласан. Эдгээр онууд нь уул уурхайн салбарт нэмэлт шууд хөрөнгө оруулалт хийгдсэн үе юм. Монгол Улс жижиг эдийн засагтай учир дэлхийн эрдэс, түүхий эдийн үнэд нөлөөлөх чадваргүй. Иймээс ГШХО-ийг нэмэгдүүлэх хамгийн тохиромжтой арга нь хөрөнгө оруулалтын орчноо сайжруулахад анхаарах юм. ГШХО-ыг хэрхэн татах талаар судлахын тулд байгалийн баялаггүй орнуудын хөрөнгө оруулалтын орчны шинжилгээг хийсэн.

Түлхүүр үгс:

Гадаадын шууд хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалтын орчин, уул уурхай, байгалийн баялаг, Монгол

Улаанбаатар, Монгол

2017

Эдийн Засгийн Судалгаа Эрдэм Шинжилгээний Хүрээлэн



Монгол Улс дахь гадаадын хөрөнгө оруулалт

Улаанбаатар

“Монгол Улс дахь гадаадын хөрөнгө оруулалт”

Судалгааны тайлан

Багийн ахлагч:
Багийн гишүүд:

З.Манлайбаатар
Б.Мөнх-Ирээдүй
Б.Дэлгэрмаа
Т.Дөлгөөн

Улаанбаатар, 2017

АГУУЛГА

УДИРТГАЛ	6
Судлагдсан байдал.....	6
Монгол дахь гадаадын хөрөнгө оруулалтын тойм	8
ГШХО-ын НӨЛӨӨ.....	12
ГШХО-ыг ТОДОРХОЙЛОГЧ	18
ГШХО-ын ТӨЛӨВ	24
ДҮГНЭЛТ	29
ХАВСРАЛТ	30
НОМ ЗҮЙ	40

Зургийн жагсаалт

Зураг 1. Монгол Улсын ГШХО-ын үрсгал, Оюу Толгой болон бусад, 2008-2016, сая \$	9
Зураг 2. 2010 (зүүн) болон 2015 (баруун) оны завсрын хэрэглээ, эх үүсвэрээр	13
Зураг 3. Хөрөнгө оруулалтын үржүүлэгч жилээр болон үр дүнгээр	16
Зураг 5. Уул уурхайн бүтээгдэхүүний индекс болон ГШХО-ын үрсгал, 2009-2016	19
Зураг 5. 2017 оны улсын төсвийн тодотгол	27
Зураг 6. Үнийн индексийн таамаглал, 2017-2020 он	27

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Макро эдийн засгийн гол үзүүлэлтүүд	8
Хүснэгт 2. Монгол Улсын эдийн засгийн өсөлт ба ГШХО-ын үрсгал, 2006-2016, тэрбум \$	9
Хүснэгт 3. ГШХО-ын үрсгал, салбараар, 2015 болон 2016 он	10
Хүснэгт 4. Топ 10н хөрөнгө оруулагчид, улсаар, 2010-2016 (хуримтлагдсан дүн)	10
Хүснэгт 5. Салбаруудын үйлдвэрлэл, ДНБ-д эзлэх %, 2010 болон 2015 он	12
Хүснэгт 6. Өсөлт, салбараар(үр дүн 1)	14
Хүснэгт 7. Нэмэгдэл өртөг салбараар, тэрбум төгрөг (үр дүн 1)	14
Хүснэгт 8. Өсөлт, салбараар (үр дүн 2)	15
Хүснэгт 9. Нэмэгдэл өртөг салбараар, тэрбум төгрөг (үр дүн-2)	16
Хүснэгт 10. Монгол болон Чили улсуудын ГШХО-ын үрсгал болон 3н индексүүд, 2012-2016	19
Хүснэгт 11. Хөрөнгө оруулалтын орчныг илэрхийлэх хамгийн их ашиглагддаг индексүүд, 2016	20
Хүснэгт 12. Хамгийн их ашиглагддаг индексүүд болон эрэмбүүд, 2016	22
Хүснэгт 13. Монгол улсын ГШХО-ын үрсгал болон хамгийн их ашиглагддаг индексүүд, 2010-2016	22
Хүснэгт 14. Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Үзэл Баримтлал 2030-д тусгагдсан гол үйл ажиллагаа	25

Товчилсон үгсийн жагсаалт

АХБ	Азийн хөгжлийн банк
ГШХО	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДБ	Дэлхийн банк
ОУВС	Олон улсын валютын сан
ҮСХ	Үндэсний статистикийн хороо

УДИРТГАЛ

Монголын эдийн засгийн өсөлт сүүлийн жилүүдэд хэлбэлзэл ихтэй, энэ хэрээр тодорхой бус байдлыг ихээр үүсгэж байна. Тухайлбал, эдийн засаг 2011 онд 17.3%-аар өссөн бол 2016 онд ердөө 1%-аар өссөн. Эдийн засгийн өсөлтийн энэ хэлбэлзлээс үүдээд эдийн засгийн өсөлтийн хөдөлгөгч хүчин зүйл юу вэ, эдгээр хүчин зүйл яаж нөлөөлдөг вэ гэсэн асуулт дэвшүүлж болно.

Сүүлийн үеийн судалгаанууд эдийн засгийн өсөлт болон гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) хоорондоо хүчтэй эерэг хамааралтайг нотолдог. Тиймээс эдийн засгийн өсөлт болон тогтвортой байдлыг дэмжихийн тулд манай улс ГШХО нэмж татах шаардлагатай.

2011 оноос хойш, Монгол дахь ГШХО хурдацтай буурч байна. Харамсалтай нь энэ талаар хийгдсэн судалгаа бараг байхгүй, ГШХО буурч байгаагийн шалтгааныг яг нарийн тодорхойлж чадаагүй байна. Хэдийгээр бүрэн хэмжээний судалгаа байхгүй ч, ихэнх эдийн засагчид ГШХО буурч буй нь уул уурхайн бүтээгдэхүүний үнэ болон хөрөнгө оруулалтын орчинтой холбоотой гэж үзэж байна.

Энэхүү судалгаагаар бид ГШХО-ын хэлбэлзлийн шалтгааныг тодорхойлох, ГШХО-ын эдийн засаг дахь нөлөөг үнэлэх, бусад улсын сайн туршлага дээр тулгуурлаж ГШХО-ыг хэрхэн татах талаар судлахыг зорилоо.

Судлагдсан байдал

2016 онд дэлхийн жилийн ГШХО-ын урсгал 2%-аар буурч 1.75 тэрбум ам.долларт хүрсэн ба энэ нь буурай хөгжилтэй болон хөгжиж буй улсууд дахь ГШХО-ын урсгал буурснаас шалтгаалж байна (UNCTAD, 2017). ГШХО нь өндөр чанартай ажлын байрыг бий болгож, буурай хөгжилтэй болон хөгжиж буй орнуудад орчин үеийн үйлдвэрлэл болон менежментийн туршлагын хэрэглээг дэмждэг ба энэ нь тухайн улс орны нийгмийн хөгжилд чухал үүрэгтэй байдаг (OECD, 2008). Гэсэн хэдий ч ихэнх судалгаанууд нь ГШХО-ын нийгмийн хөгжил дэх нөлөөнөөс илүү эдийн засгийн өсөлт дэх нөлөөнд төвлөрдөг.

ГШХО нь эдийн засгийн өсөлтөд чухал нөлөөтэй (Hansen & Rand, 2006). Iqbal & Shaikh (2010) нар ГШХО нь худалдааг дэмждэг хэдий ч ГШХО болон худалдаа нь Пакистаны эдийн засгийн өсөлтийг түргэсгэх гол 2 хүчин зүйл мөн гэж дүгнэсэн. Almfraji, Almsafir & Uao (2014) нар нь ГШХО болон эдийн засгийн өсөлт хоорондоо хамааралтай ба ГШХО өсөлтийг дэмжиж байхад өсөлт нь эргээд ГШХО-ыг татаж байдаг хэмээн дурдсан (Almfraji, Almsafir, & Uao, 2014).

Судлаачид эдийн засгийн өсөлтөд үзүүлэх ГШХО-ын нөлөөний талаар зөвшилцөлд хүрээгүй байна. Зарим судалгаанууд ГШХО нь эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөөтэй гэлцдэг. Тухайлбал богино хугацаанд ГШХО нь өсөлтийг дэмждэг хэдий ч урт хугацаандаа ГШХО-аас хэт хамааралтай байх нь сөрөг нөлөөтэй. Дэд бүтэц болон байгууллагууд нь гадаадын хөрөнгө оруулалтыг дэмждэг ч энэ нь ажилгүйдэл, хэт хотжилт болон орлогын тэгш бус байдлын шалтгаан болдог (Dixon & Boswell, 1996). Энэ санааг дэмждэг жишээнүүд нь буурай хөгжилтэй орнууд болох Нигер, Гондурас болон Мянмар гэх мэт улсуудад ажиглагддаг (Kentor & Boswell, 2003). Kentor & Boswell (2003) нар нь 39 буурай хөгжилтэй орны ГШХО-ын төвлөрөл болон үндэсний нийт бүтээгдэхүүнийг ашиглан /cross national/ панел регрессийн загварыг байгуулсан. Энэ загвар нь ГШХО-ын төвлөрөл өндөртэй буурай хөгжилтэй орнууд экспортын татвараас өндөр хамааралтай бөгөөд арвилгалд өртөмтгий байгааг харуулсан.

ГШХО-д нөлөөлөгч гол хүчин зүйлсийн нэг нь захиргаа болон институтын орчин юм. Тухайлбал өндөр орлоготой хөгжиж буй орнуудад ГШХО нь өсөлтийг дэмждэг бол бага орлоготой орнуудад институтын орчин нь өөр байдаг тул ГШХО нь өсөлтийг дэмждэггүй (Blomstrom, Lipsey, & Zejan, 1992).

Захиргаа болон институтийн орчныг хөрөнгө оруулалтын орчин гэж хэлж болох бөгөөд хөрөнгө оруулалтын орчны хэлбэр нь ГШХО-д ихээхэн нөлөөтэй байдаг. Quazi & View (2007) нар Латин Америкт хийсэн судалгаагаараа хөрөнгө оруулалтын орчин болон ГШХО-ын хооронд хүчтэй эерэг хамаарал байгааг харуулсан. Nnadozia (2011) нь ашигт малтмалын нөөц багатай Африкийн жижиг улс нь бизнесийн зохицуулалтын шинэчлэлийг бий болгосон тохиолдолд ГШХО-ыг татах боломжоо нэмэгдүүлэх боломжтой гэж дурдсан байна. Энэ шинэчлэл нь бизнесийн таатай орчныг бүрдүүлж, хөрөнгө оруулалтын орчныг хөрөнгө оруулагчдад илүү таатай болгодог. Гэсэн хэдий ч худалдааны саад бэрхшээл, дарангуйлах татварын болон бусад хязгаарлагдмал бодлогын өөрчлөлт нь ГШХО-д сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

Монгол дахь ГШХО-ыг судалсан цөөн хэдэн судалгаа байдгаас бид ГШХО болон эдийн засгийн өсөлтийн хамаарлыг тайлбарласан 2 судалгааг авч үзлээ.

Ананд (2011) нь тогтмол нөлөөтэй энгийн шугаман регрессийн загвар ашигласан судалгаандаа ГШХО нь эдийн засгийн өсөлтөд шууд болон шууд бусаар нөлөөлдөг хэмээн дүгнэсэн. Тухайлбал, ГШХО нь зарим салбаруудын үйлдвэрлэлд сөрөг нөлөө үзүүлж байсан бөгөөд ялангуяа уул уурхайн салбарт сөрөг нөлөөтэй байсан.

Мөнхцэцэг ба Гантөмөр (2015) нар нь 2010-2013 оны Орц- Гарцын хүснэгтээс тооцоолсон Леонтийн урвуу матрицыг ашиглан 20 салбар дахь ГШХО-ын нөлөөг үнэлсэн. Тэд уул уурхайн салбар дахь ГШХО нэг хувиар өсвөл нийт эдийн засагт хэрхэн нөлөөж байгааг судалсан. ГШХО нэмэлтээр 1% өссөн нөхцөлд эдийн засаг 2010, 2011, 2012 болон 2013 онуудад харгалзан 1.5, 2.45, 1.43 болон 0.63 аар өсөх хариу үйлдэл үзүүлсэн. Нэмэгдэл ГШХО нь уул уурхай болон худалдааны салбарт хамгийн их нөлөөтэй байсан. Гэсэн хэдий ч, энэ хоёр салбар нь хоорондоо өндөр корреляци хамааралтай тул ГШХО-ын шок нь уул уурхайн салбарыг дэмжиж улмаар худалдааны салбарыг өсгөхөд хүргэж болзошгүй. Өөрөөр хэлбэл, худалдааны салбар нь ГШХО-ын урсгалаас илүүтэй уул уурхайн салбарын өсөлтөөс хамааралтай байж болно (Мөнхцэцэг, & Гантөмөр., 2015).


Хэдийгээр эдгээр судалгаа нь Монгол улсын тоон мэдээлэлд суурилсан боловч ГШХО нь тодорхой хэдэн салбаруудад эерэг болон сөрөг нөлөөтэй байна гэж дүгнэх боломжгүй байгаа ба ГШХО нь нийт эдийн засагт бүхэлд нь нөлөөтэй байгааг харж болно. Энэ судалгаа нь Монгол Улс дахь ГШХО-ын урсгалын талаарх нэгдсэн ойлголтыг өгөх бөгөөд хэрхэн ГШХО-ыг татах аргууд болон түүний үр дүнд төвлөрөх болно.

Монгол дахь гадаадын хөрөнгө оруулалтын тойм

Монголын эдийн засаг хурдацтай өсөж байна. Тухайлбал, 1995 онд ДНБ 1.4 тэрбум ам.доллар байсан бол 2016 онд 11.2 тэрбум ам.долларт хүрч бараг 8 дахин өсжээ. Доорх зурагт үзүүлснээр эдийн засгийн өсөлт 2006-2010 онд дунджаар 6.6%, 2011-2015 онд дунджаар 8.7% хүрсэн.

2008 оны дэлхийн санхүүгийн хямрал, байгалийн гамшгаас шалтгаалан 2009 онд Монголын эдийн засаг уналтад орсон. Тухайлбал, зуд болон гангийн улмаас хөдөө аж ахуйн салбар хүндэрсэн. Тус онд ГШХО 624 сая ам.доллартой тэнцэж байсан бол 2010 онд 1.7 тэрбум ам.доллар болж өссөн. Ингэснээр 2010 онд эдийн засгийн өсөлт эргээд сэргэжээ.

Хүснэгт 1. Макро эдийн засгийн гол үзүүлэлтүүд

	2006-2010	2011-2015	ДНБ салбараар (2016 онд)	
Хүн ам				
Нийт (сая)	2.7 (2010 онд)	3.1 (2015 онд)		
Нийслэл Улаанбаатар (дундаж %)	43.0	45.9		
Хот суурин газар (дундаж %)	64.9	67.5		
ДНБ				
Нэг хүнд ногдох ДНБ(одоогийн олон улсын \$)	1895.3	4128.6		
Жилийн дундаж өсөлт (%)	6.6%	8.8%		
Макро эдийн засгийн орчин				
M2 жилийн дундаж өсөлт (%)	34.99 ¹ %	17.38%	Голлох эдийн засгийн үйл ажиллагаа (2016 оны ДНБ-д эзлэх %)	
Гадаад валютын нөөц (одоогийн сая \$)	1198.28	2359.48	Уул уурхайн олборлолт	19.96%
Хэрэглээний үнийн индекс (ХҮИ: 2005.XII=100)			Хөдөө аж ахуй	12.20%
Улсын төсвийн алдагдал (ДНБ-д эзлэх %)	-0.71%	-4.33%	Бөөний болон жижиглэнгийн худалдаа	11.32%
Валютын ханш (₮/\$)	1260.40	1666.32	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	6.82%
Худалдаа			Аж үйлдвэрлэл	6.67%
Экспорт болон Импорт (одоогийн сая \$)	4,578.32	10,528.91	Санхүү болон даатгалын үйл ажиллагаа	5.29%
Бүтээгдэхүүн, үйлчилгээний экспорт (ДНБ-д эзлэх %)	43.54%	40.58%	Тээвэр, агуулах	5.22%
Бүтээгдэхүүн, үйлчилгээний импорт (ДНБ-д эзлэх %)	47.91%	48.78%	Голлох уул уурхайн бүтээгдэхүүн (2016 оны нийт экспортод эзлэх %)	
Ажил эрхлэлтийн үзүүлэлтүүд			Нийт экспорт (одоогийн сая \$)	4,917.30
Эдийн засгийн идэвхгүй хүн ам (нийт дүнд эзлэх %)	38.97%	38.50%	Зэсийн баяжмал	32.69%
Ажиллах хүчний оролцооны түвшин	61.02%	61.50%	Нүүрс	19.79%
Ажил эрхлэлтийн түвшин	54.36%	56.72%	Алт	15.42%
Ажилгүйдлийн түвшин	10.92%	7.74%	Газрын тос	6.86%
Дундаж цалин (мянган ₮)	264.44	609.72	Төмрийн хүдэр	5.08%

Эх сурвалж: Дэлхийн банк, Үндэсний статистикийн хороо (ҮСХ), Монгол Банк

¹ M2 мөнгөний жилийн дундаж өсөлт: 2006 онд 34.8%; 2007 онд 56.3%; 2008 онд (-0.05)% ; 2009 онд 26.9%; 2010 онд 62.5%

Монгол Улс 1993 онд ГШХО-ыг дэмжих зорилгоор “Гадаадын шууд хөрөнгө оруулалтын бодлого”-ыг санаачлан хэрэгжүүлж эхэлсэн хэдий ч 2010 он хүртэл ГШХО-ын урсгал 1 тэрбум ам.долларт хүрээгүй байсан бол 2011 онд 4.6 тэрбум ам.долларт хүрчээ.

Хүснэгт 2. Монгол Улсын эдийн засгийн өсөлт ба ГШХО-ын урсгал, 2006-2016, тэрбум \$

	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
ДНБ-ий өсөлт	8.6%	10.2%	8.9%	-1.3%	6.4%	17.3%	12.3%	11.6%	7.9%	2.4%	3.0%
ГШХО	0.2	0.4	0.8	0.6	1.7	4.6	4.3	2.1	0.3	0.1	-4.2
Өсөлт	31%	52%	127%	-26%	171%	170%	-7%	-52%	-84%	-72%	-4511%

Эх сурвалж: Монголбанк, УСХ


2008 оноос ГШХО эрчимтэй өсөж эхэлсэн боловч дэлхий нийтийг хамарсан санхүү эдийн засгийн хямралаас үүдэж 2009 онд энэхүү өсөлт тасалдсан бөгөөд 2010, 2011 онуудад эргээд өндөр өсөлтийг үзүүлсэн. Эдийн засагчдын үзэж байгаагаар энэхүү огцом өсөлт нь голчлон уул уурхайн салбарын өсөлтөөс үүдсэн бөгөөд уул уурхайн салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар богино хугацаанд ГШХО-ыг өсөх боломжтой.

2009 онд Монгол Улс дэлхийн нийт зэс болон нүүрсний 0.8% болон 0.2%-ыг тус тус үйлдвэрлэжээ (British Geological Survey, 2011). 2010 онд Монгол Улс дэлхийн нийт нүүрсний 0.7%-ийг үйлдвэрлэсэн ба үүнээс хойш Монголын нүүрсний үйлдвэрлэлийн дэлхийн нийт нүүрсний үйлдвэрлэлд эзлэх хувь үл ялиг өсөлттэй байгаа. Мөн Монгол Улс нь БНХАУ-ын коксжих нүүрсний импортын 20-30%-ийг нийлүүлдэг (Эдийн засгийн судалгаа эрдэм шинжилгээний хүрээлэн, 2017a).

ГШХО-аар хэрэгждэг хамгийн том уул уурхайн төслүүдийн нэг болох Оюу Толгой төсөл хэрэгжиж эхэлснээс хойш Монгол Улсын зэсийн үйлдвэрлэл огцом өсөж дэлхийн нийт зэсийн 1.8%-ийг үйлдвэрлэх болсон бөгөөд дэлхийд зэсийн үйлдвэрлэлээрээ 15 дугаар байранд эрэмбэлэгдэх болжээ (Эдийн засгийн судалгаа эрдэм шинжилгээний хүрээлэн, 2017b). Эдийн засгийн судалгаа эрдэм шинжилгээний хүрээлэн, 2017b-д Оюу Толгойн хүлээгдэж буй үйлдвэрлэлтэй холбоотойгоор Монгол Улсын зэсийн үйлдвэрлэл ойрын ирээдүйд бага зэрэг өсөлт үзүүлнэ гэжээ.

Хүснэгт 2т үзүүлснээр ГШХО-ын урсгал эдийн засгийн өсөлтийг шууд дэмждэг байна. Гэсэн хэдий ч, эдийн засгийн өсөлт нь гол төлөв уул уурхайн салбараас ялангуяа Оюу Толгой төслөөс хамааралтай байна. Дараах зураг нь ГШХО-ын урсгал дахь Оюу Толгой төслийн нөлөөллийг харуулж байна.

Зураг 1. Монгол Улсын ГШХО-ын урсгал, Оюу Толгой болон бусад, 2008-2016, сая \$



Эх сурвалж: Монгол Банк, Судалгааны багийн тооцоолол

Оргил жил болох 2011 онд Оюу толгой төслийн ГШХО-ын урсгал нэмэгдэж 2.5 тэрбум ам.долларт хүрсэн ба нийт ГШХО-ын (4.6 тэрбум ам.доллар) урсгалын 54%-ийг эзэлж байв. 2016 онд ГШХО-ын урсгал -4.2 тэрбум ам.долларт хүрч огцом буурчээ. Гэсэн хэдий боловч доорх хүснэгтэд харуулснаар санхүү, даатгал болон барилгын салбар дахь ГШХО-ын урсгал тус тус 43 сая ам.доллар болон 39 сая ам.доллараар өссөн. ГШХО -4.2 тэрбум ам.долларт хүрч буурсан нь Оюу толгойн хөрөнгө оруулалтын дахин хуваарилалтаас шалтгаалсан².

Хүснэгт 3. ГШХО-ын урсгал, салбараар, 2015 болон 2016 он

№	Салбар	2015	2016	Өөрчлөлт%
1	Барилга	43.4	82.5	39.1 ▲
2	Боловсрол	1.8	0.8	-1.0 ▼
3	Боловсруулах үйлдвэрлэл	18.1	-393.0	-411.1 ▼
4	Бөөний болон жижиглэн худалдаа	117.6	62.9	-54.7 ▼
5	Зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээ	128.9	99.2	-29.7 ▼
6	Харилцаа холбоо	12.8	6.8	-6.1 ▼
7	Мэргэжлийн шинжлэх ухаан, техник технологи, бусад бизнес	28.4	-10.8	-39.2 ▼
8	Санхүү болон даатгалын үйлчилгээ	45.5	89.0	43.5 ▲
9	Тээврийн үйлчилгээ	25.0	3.6	-5.6 ▼
10	Захиргаа болон туслах үйл ажиллагаа	9.3	5.3	-19.7 ▼
11	Уул уурхай	-369.2	-4164.5	-3795.3 ▼
12	Бусад үйлчилгээ	-20.3	4.9	25.3 ▲
13	Үл хөдлөх хөрөнгийн үйлчилгээ	35.9	45.0	9.1 ▲
14	Хөдөө аж ахуй, ой мод, загасчлал	6.6	4.9	-1.7 ▼
15	Цахилгаан, хий, уур ба эдгээрийн хангамж	6.2	12.0	5.8 ▲
16	Бусад	4.4	-4.7	-8.8 ▼
	Нийт	94	-4156	-4250 ▲

Эх сурвалж: Шууд хөрөнгө оруулалтын судалгаа (2009-2017 I улирал), Монголбанк

Дор дурдсан хүснэгтэд Монгол Улсын ГШХО-ын топ 10н хөрөнгө оруулагч улсуудын жагсаалтыг харуулав. 2011 он хүртэл БНХАУ нь хамгийн том хөрөнгө оруулагч орон байсан бол 2011 оноос хойш Нидерланд улсаас орж ирсэн ГШХО-ын урсгал маш ихээр нэмэгджээ³.

Хүснэгт 4. Топ 10н хөрөнгө оруулагчид, улсаар, 2010-2016 (хуримтлагдсан дүн)

Улс	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Нийт ГШХО (сая \$)	4407	9818	13458	15729	16693	16753	12980
Нидерланд	385	1344	7637	8308	8649	8385	4406
БНХАУ	112	4781	1201	1254	2345	2440	2933
Сингапур	360	172	1424	1272	1393	1386	1322
Их британи	617	773	906	1202	1264	1198	1011
АНУ	69	604	259	362	521	546	559
Австрали	1	143	125	2033	459	442	514
Япон	90	596	115	168	109	403	465
Канад	21	526	94	135	345	403	424
Люксембург	133	18	122	264	373	351	351

Эх сурвалж: Шууд хөрөнгө оруулалтын судалгаа (2009-2017 I улирал), Монголбанк

² Оюу Толгой болон Засгийн газрын хооронд гэрээ хийснээс хойш буюу 2009 оноос хойш Засгийн газрын 34%-ийн ногдол нь төлбөрийн тэнцэлд ГШХО-аар бүртгэгддэг байсан. Гэсэн хэдий ч, 2016 онд ангилал өөрчлөгдсөний улмаас өмнө бүртгэгдсэн ГШХО-ыг гадаад зээл гэж бүртгэсэн.

³ Судалгааны баг Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг ГШХО-д хамгийн их хувь нэмэр оруулдаг топ 20 компанийн жагсаалтыг гаргасан бөгөөд эдгээрийн 7 нь уул уурхайн салбарт, 4 нь банкны салбарт үйл ажиллагаа явуулдаг (компаниудын жагсаалтыг хавсралт дахь Хүснэгт Х1-ээс харна уу).

ГШХО-ыг хамгийн ихээр татдаг салбар нь уул уурхай юм. Жил ирэх тусам уул уурхайн салбар дахь ГШХО-ын урсгалын өөрчлөлт Монгол Улсын эдийн засагт ихээхэн нөлөөтэй болж байгаа ба эдийн засаг дахь бүтцийн өөрчлөлтийн шалтгаан болж байна. Дараагийн бүлэгт жил бүр уул уурхайн салбарт орж байгаа нэмэгдэл ГШХО-ын урсгалын нийт эдийн засагт үзүүлж буй нөлөөнд дүн шинжилгээ хийнэ.

ГШХО-ын НӨЛӨӨ

Монголын эдийн засаг дахь ГШХО-ын нөлөөг шинжлэхдээ 2010 болон 2015 оны Орц-Гарцын хүснэгтийн тоон мэдээллийг ашигласан. Учир нь энэ 2 жилийн эдийн засгийн бүтэц нь харьцангуй ялгаатай юм.

Хүснэгт 5. Салбаруудын үйлдвэрлэл, ДНБ-д эзлэх %, 2010 болон 2015 он


Салбарууд	2010	2015	Өөрчлөлт
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	11.73%	13.36%	1.62% ▲
Уул уурхай, олборлолт	21.55%	17.09%	-4.46% ▼
Боловсруулах үйлдвэрлэл	6.81%	7.64%	0.82% ▲
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	1.95%	1.64%	-0.31% ▼
Усан хангамж,бохир ус, хог, хаягдлын менежмент	0.32%	0.45%	0.13% ▲
Барилга	2.56%	4.22%	1.66% ▲
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар үйлчилгээ	12.29%	11.53%	-0.75% ▼
Тээвэр, агуулах	6.95%	5.23%	-1.72% ▼
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	0.54%	0.93%	0.39% ▲
Мэдээлэл, харилцаа	2.62%	2.15%	-0.48% ▼
Санхүү, даатгалын үйл ажиллагаа	2.46%	5.35%	2.90% ▲
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	7.05%	6.85%	-0.20% ▼
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1.36%	2.19%	0.84% ▲
Удирдлага болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	0.83%	0.94%	0.11% ▲
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	4.36%	4.58%	0.22% ▲
Боловсрол	3.89%	4.38%	0.49% ▲
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	1.71%	2.04%	0.33% ▲
Урлаг, үзвэр, тоглоом, наадам	0.33%	0.46%	0.13% ▲
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	0.46%	0.81%	0.36% ▲
Бүтээгдэхүүний цэвэр татвар	10.23%	8.15%	-2.09% ▼

Эх сурвалж: ДНБ салбараар, ҮСХ

2010 болон 2015 оны эдийн засгийн бүтцийг харьцуулбал уул уурхайн салбарын ДНБ-д эзлэх хувь 4.5%-аар буурсан ба энэ нь ГШХО-ын урсгал болон уул уурхайн бүтээгдэхүүнүүдийн үнийн бууралтаас шалтгаалжээ. Судалгааны баг зөвхөн энэ хэсэг дахь уул уурхайн салбарт хийгдэж байгаа ГШХО-ын нэмэлт урсгалын нөлөөг тооцоолсон. Уул уурхайн салбар дахь ГШХО-ын нэмэлт урсгал нь бусад бүх салбаруудад зардлаа нэмэгдүүлэхийг өдөөх ба ингэснээр эдийн засгийн үйл ажиллагааг нэмэгдүүлнэ. Дараах тооцоололд ГШХО-ын нэмэлт урсгал нь уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн 1%-тай тэнцүү байна.

Зураг 2-т уул уурхайн салбар дах нэмэгдэл ГШХО-ын нөлөө дотоод болон гадаадын зах зээлд хэрхэн хуваагдаж байгааг харуулж байна. Жишээлбэл, 2010 онд уул уурхайн салбар дотоодын зах зээлийн нийт завсрын хэрэглээний 59%-ийг хэрэглэсэн бол 2015 онд 70%-ийг хэрэглэсэн байна. Дотоодын зах зээл илүү их хөрөнгө оруулалтыг шингээх тусам эдийн засагт үзүүлэх нөлөө илүү их байх учраас нэмэгдэл ГШХО-ын эдийн засаг дахь нөлөө нь 2010 онтой харьцуулахад 2015 онд арай илүү байна.

Зураг 2. 2010 (зүүн) болон 2015 (баруун) оны завсрын хэрэглээ, эх үүсвэрээр



Эх үүсвэр: 2010, 2015 оны орц-гарцын хүснэгт, ҮСХ, судалгааны багийн тооцоолол

Дараах хэсэгт уул уурхайн салбар дах ГШХО-ын нөлөөг салбар бүрээр харуулах болно. Энэ судалгаанд 2011⁴ оны орц-гарцын хүснэгтийг ашиглан завсрын хэрэглээг салбар бүрээр задалсан тоог гарган авсан ба үүнийг уул уурхайн салбар дах нэмэгдэл ГШХО-ын нөлөөг салбар бүрээр харуулахад ашиглалаа (хавсралтын хүснэгт Х2-оос уул уурхайн салбарын дотоодын завсрын хэрэглээний хувийг харна уу).

Нэмэгдэл ГШХО-ын нийт эдийн засаг дахь нөлөөг тооцоолохын тулд дараах шугаман системийг ашиглав.

$$A \cdot y + B \cdot x = 0$$

Энд y нь эндоген хувьсагчдын вектор, x нь экзоген хувьсагчдын вектор, A болон B нь коэффициентын матриц: мөр бүхэн нэг тэгшитгэлийг, багана бүр нэг хувьсагчийг илэрхийлнэ.

Доорх тэгшитгэлд y нь x -ийн функцээр хэрхэн тодорхойлогдохыг харуулав:

$$y = -A^{-1}B \cdot x$$

A^{-1} нь A -гийн урвуу матриц бөгөөд өөрөөр Леонтивийн урвуу матриц гэдэг.

Дээрх аргачлалын дагуу уул уурхайн салбарт орж байгаа уул уурхайн салбарын 1%-ийн үйлдвэрлэлтэй тэнцэх хэмжээний ГШХО-ын нэмэлт урсгалын нөлөө нь 2010 болон 2015 онуудад харгалзан 59% ба 70% дотоодод шингэдэг (үр дүн-1) болон 100% дотоодод шингэдэг (үр дүн-2) гэсэн 2 хувилбарт тооцооллыг хийлээ.

Хүснэгт 6 болон 7-д уул уурхайн салбарт нэмэлтээр орж буй ГШХО-ын нөлөө 2010 болон 2015 онуудад харгалзан 59% ба 70% дотоодод шингэдэг тохиолдлыг авч үзье. Тооцооллын дагуу уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн нэг хувьтай тэнцэх ГШХО-ын нэмэлт урсгал нь 2010 болон 2015 онуудад эдийн засгийг харгалзан 0.188% болон 0.207%-аар тус тус өсгөнө. Дор харуулсан хүснэгтэд уул уурхайн салбар дах ГШХО-ын нэмэлт урсгалаас шалтгаалан салбарууд хэд хэдэн хувиар өсөж байгааг харууллаа.

⁴ 2011 онд ГШХО-ын урсгал түүхэн дээд хэмжээндээ хүрч 4.6 тэрбум ам. долларт хүрсэн ба энэ үеийг ГШХО-ын нэмэгдэл урсгалын эдийн засагт үзүүлэх нөлөөг харуулах оновчтой жил хэмээн үзлээ.

Хүснэгт 6. Өсөлт, салбараар(үр дүн 1)

Салбарууд	2010	2015
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	0.05% ▲	0.08% ▲
Уул уурхай, олборлолт	0.04% ▲	0.05% ▲
Боловсруулах үйлдвэрлэл	0.24% ▲	0.20% ▲
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	0.71% ▲	0.48% ▲
Усан хангамж,бохир ус, хог, хаягдлын менежмент	0.88% ▲	0.38% ▲
Барилга	0.57% ▲	0.64% ▲
Бөөний, жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар	0.27% ▲	0.27% ▲
Тээвэр, агуулах	0.68% ▲	0.73% ▲
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	0.91% ▲	0.44% ▲
Мэдээлэл, харилцаа	0.21% ▲	0.19% ▲
Санхүү, даатгалын үйл ажиллагаа	0.58% ▲	0.25% ▲
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.05% ▲	0.05% ▲
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	0.43% ▲	0.24% ▲
Удирдлага болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	0.56% ▲	0.47% ▲
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	0.08% ▲	0.05% ▲
Боловсрол	0.03% ▲	0.02% ▲
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	0.05% ▲	0.03% ▲
Урлаг, үзвэр, тоглоом, наадам	0.07% ▲	0.04% ▲
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	0.11% ▲	0.06% ▲
Нийт	0.188% ▲	0.207% ▲

Эх сурвалж: судалгааны багийн тооцоолол

Хүснэгт 6-д харуулснаар уул уурхайн салбар дах ГШХО-ын нэмэлт урсгалын зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, усан хангамж, цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж болон барилга зэрэг үйлчилгээний салбаруудад үзүүлэх нөлөө маш их байгаа ба энэ нөлөө нь 2010 болон 2015 онуудад адил байна. Хүснэгт 7 нь уул уурхайн салбар дах ГШХО-ын нэмэлт урсгал нь хэр их нэмэгдэл өртөг үүсгэж байгааг харуулж байна.

Хүснэгт 7. Нэмэгдэл өртөг салбараар, тэрбум төгрөг (үр дүн 1)

Салбарууд	2010	2015
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	0.59	2.55
Уул уурхай, олборлолт	0.83	1.78
Боловсруулах үйлдвэрлэл	1.61	3.47
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	1.34	1.82
Усан хангамж,бохир ус, хог, хаягдлын менежмент	0.27	0.40
Барилга	1.42	6.23
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар үйлчилгээ	3.28	7.25
Тээвэр, агуулах	4.63	8.79
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	0.48	0.94
Мэдээлэл, харилцаа	0.55	0.95
Санхүү, даатгалын үйл ажиллагаа	1.39	3.08
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.37	0.76
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	0.57	1.20
Удирдлага болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	0.45	1.02
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	0.33	0.48
Боловсрол	0.11	0.16
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	0.08	0.15
Урлаг, үзвэр, тоглоом, наадам	0.02	0.04

Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	0.05	0.11
Нэмэгдэл ДНБ-ийн хэмжээ	18.38	41.17
Нэмэгдэл хөрөнгө оруулалтын хэмжээ	21.0	39.5

Эх сурвалж: Судалгааны багийн тооцоолол

2015 онд тээвэр, агуулах (8.79 тэрбум төгрөг), бөөний болон жижиглэн худалдаа (7.25 тэрбум төгрөг) болон барилгын салбар (6.23 тэрбум төгрөг) зэрэг салбаруудад хамгийн их нөлөө үзүүлсэн. 2015 онд ГШХО-ын нэмэлт урсгал 39.5 тэрбум төгрөг боловч эдийн засаг дахь нөлөөлөл нь 41.17 тэрбум төгрөг байна. Хөрөнгө оруулалтын үржүүлэгч нь 1.04 нэгж байна. 2010 онд энэ үржүүлэгч 0.87 нэгж байгаа ба нэмэгдэл ГШХО болон эдийн засаг дахь нөлөөлөл нь харгалзан тус бүр 21 тэрбум төгрөг, 18.4 тэрбум төгрөг байна.

2010 болон 2015 онуудад дотоодын зах зээл дэх завсрын хэрэглээ 11%-аар ялгаатай байгаа тул хөрөнгө оруулалтын үржүүлэгчид мөн ялгаатай байна. Дотоодын зах зээлийн татсан хөрөнгө оруулалт их байх тусам эдийн засагт үзүүлэх нөлөөлөл их байдаг. Мөн эдийн засгийн бүтцийн өөрчлөлт нь хөрөнгө оруулалтын үржүүлэгчид нөлөөлдөг. Сүүлийн жилүүдэд уул уурхайн салбарын өндөр өсөлтөөс шалтгаалж эдийн засагт бүтцийн өөрчлөлт бие болсон. Дараах хүснэгтэд уул уурхайн салбар дахь нэмэгдэл ГШХО-ын нөлөө тэр чигээрээ дотоодын эдийн засагт шингэж байгаа тохиолдолд салбарууд хэдэн хувиар өсөхийг харууллаа. Энэ тооцооллын үр дүнд хөрөнгө оруулалтын үржүүлэгчид ялгаатай гарсан нь зөвхөн эдийн засгийн бүтцийн өөрчлөлтөөс шалтгаалж байна.

Уул уурхайн салбарын нэмэгдэл ГШХО-ын урсгалын нөлөө 100% дотоодод шингэдэг тохиолдолд уул уурхайн ГШХО-ыг нэмэгдүүлэхэд эдийн засагт ямар нөлөө үзүүлэхийг авч үзье. Тооцооллын дагуу уул уурхайн салбар дахь нэмэгдэл ГШХО нь эдийн засгийг 2010 болон 2015 онуудад 0.32% болон 0.25%-аар өсгөх нөлөөтэй байна. Цахилгаан, усан хангамж, тээвэр, агуулах болон зочид буудал, нийтийн хоолны салбар гэх мэт салбаруудад шокийн нөлөө нь 2010 онд эерэг өсөлтийг бие болгож байгаа бол 2015 онд зөвхөн тээвэр, агуулахын салбарт өндөр өсөлтийг бие болгож байна.

Хүснэгт 8. Өсөлт, салбараар (үр дүн 2)

Салбарууд	2010	2015
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	0.09%	0.12%
Уул уурхай, олборлолт	0.07%	0.06%
Боловсруулах үйлдвэрлэл	0.41%	0.28%
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	1.20%	0.68%
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент	1.50%	0.54%
Барилга	0.97%	0.91%
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар үйлчилгээ	0.47%	0.39%
Тээвэр, агуулах	1.16%	1.03%
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	1.56%	0.62%
Мэдээлэл, харилцаа	0.37%	0.27%
Санхүү, даатгалын үйл ажиллагаа	0.99%	0.35%
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.09%	0.07%
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	0.73%	0.34%
Удирдлага болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	0.95%	0.66%
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	0.13%	0.06%
Боловсрол	0.05%	0.02%
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	0.08%	0.04%
Урлаг, үзвэр, тоглоом, наадам	0.12%	0.06%
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	0.18%	0.08%
Эдийн засгийн өсөлт	0.321%	0.253%

Эх сурвалж: Судалгааны багийн тооцоолол

2010 онд тээвэр болон агуулах (7.9 тэрбум төгрөг), бөөний болон жижиглэн худалдаа (5.6 тэрбум төгрөг) ба барилгын салбарууд (2.75 тэрбум төгрөг) нь их хэмжээний өсөлттэй байсан бол 2015 онд тээвэр болон агуулах ба бөөний, жижиглэн худалдааны гэсэн 2 салбарт маш их хэмжээний өсөлт бие болсон. Уул уурхайн салбар дах нэмэгдэл ГШХО нь тээвэр, агуулах болон бөөний, жижиглэн худалдааны салбаруудыг 2010 болон 2015 онуудад нийлээд их хэмжээгээр дэмжиж байна.


Хүснэгт 9. Нэмэгдэл өртөг салбараар, тэрбум төгрөг (үр дүн-2)

Салбарууд	2010	2015
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1.02	3.63
Уул уурхай, олборлолт	1.41	2.54
Боловсруулах үйлдвэрлэл	2.75	4.94
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	2.29	2.59
Усан хангамж,бохир ус, хог, хаягдлын менежмент	0.47	0.56
Барилга	2.42	8.86
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар үйлчилгээ	5.60	10.32
Тээвэр, агуулах	7.90	12.51
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	0.82	1.34
Мэдээлэл, харилцаа	0.94	1.35
Санхүү, даатгалын үйл ажиллагаа	2.38	4.38
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.63	1.08
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	0.97	1.71
Удирдлага болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	0.77	1.45
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	0.57	0.68
Боловсрол	0.19	0.22
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	0.14	0.21
Урлаг, үзвэр, тоглоом, наадам	0.04	0.06
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	0.08	0.15
Нэмэгдэл ДНБ-ийн хэмжээ	31.37	58.58
Нэмэгдэл хөрөнгө оруулалтын хэмжээ	21.02	39.56

Эх сурвалж: судалгааны багийн тооцоолол

Доорх зурагт 2010 болон 2015 оны хувьд үр дүн-1 болон үр дүн-2-ын үржүүлэгчийн ялгааг харууллаа.

Зураг 3. Хөрөнгө оруулалтын үржүүлэгч жилээр болон үр дүнгээр



Эх сурвалж: Судалгааны багийн тооцоолол

Үр дүн-2-ийн хувьд хөрөнгө оруулалтын үржүүлэгч нь үр дүн-1-ээс харьцангуй их байгаа ба энэ нь уул уурхайн салбар дах нэмэгдэл ГШХО дотоодын зах зээл хэр их шингэж байгаагаас шалтгаалж байна. Үр дүн-2т уул уурхайн салбар дах нэмэлт ГШХО тэр чигээрээ дотоодын зах зээлд шингэж байгаа тул хөрөнгө оруулалтын үржүүлэгч нь 2010 онд 1.49, 2015 онд 1.48 байна. Энэ үл ялиг зөрүү нь эдийн засаг дахь бүтцийн өөрчлөлттэй холбоотой юм. Үр дүн-1 дэх үржүүлэгчдийн зөрүү нь эдийн засгийн бүтцийн шилжилт болон уул уурхайн салбар дах нэмэлт ГШХО нь дотоодын эдийн засагт хэр шингэж байгаагаас хамаарч байна.

Дүгнэж хэлбэл, ГШХО-ын урсгал нь Монгол улсын эдийн засагт чухал нөлөөтэй байна. Салбаруудад үзүүлж байгаа шууд нөлөөлөл нь уул уурхайн салбар дах нэмэлт ГШХО-ын салбарууд дах хуваарилалт болон хэдэн хувь нь дотоодын эдийн засагт шингэж байна вэ гэдгээс шалтгаална. Тооцооллын дагуу, уул уурхайн салбар дах нэмэлт ГШХО-ын аль болох их хэсэг нь дотоодын зах зээлд шингэж байх юм бол нэмэлт ГШХО-ын урсгалын нөлөө нь тэр чинээгээрээ их байдаг байна. Мөн уул уурхайн салбар нь капиталыг ихээр хэргэлдэг, дотоодын аж үйлдвэрийн салбар машин механизм, тоног төхөөрөмж нийлүүлэх боломжгүй байдгаас уул уурхайн салбар дахь уул уурхайн салбар дах нэмэлт ГШХО нь импортыг нэмэгдүүлдэг. Улмаар аж үйлдвэрийн салбарын хөгжил нь харьцангуй сул хэвээр байсаар байна. Тиймээс Монгол улс нь хөрөнгө оруулалтын үржүүлэгчийг нэмэгдүүлэхийн тулд аж үйлдвэрийн салбараа хөгжүүлэх шаардлагатай байна.

ГШХО-ыг ТОДОРХОЙЛОГЧ

Уул уурхайн салбар нь Монгол улсын ГШХО татдаг гол салбар юм. Фрасер институт (2016) нь хөрөнгө оруулах шийдвэрт юу нөлөөлдгийг тодорхойлохоор дэлхийн даяар уул уурхай, хайгуулын компаниудаас судалгаа⁵ авчээ. Энэ судалгаагаар Ашигт малтмалын боломжийн индекс (MPI) болон Бодлогын ойлголтын индекс (PPI) гэсэн 2 индексийг ашиглан Хөрөнгө оруулалт таталтын индекс (IAI) гэсэн индексийг гарган авсан. Энэхүү индекс нь ашигт малтмалын өгөөж болон улс төрийн хүчин зүйлтэй холбоотой юм. Ашигт малтмалын боломжийн индекс нь геологийн хувьд хөрөнгө оруулагчдын анхаарлыг хэр татаж байгааг хэмждэг бол бодлогын ойлголтын индекс нь хайгуулын хөрөнгө оруулалтын талаарх хандлага дахь улс төрийн бодлогын нөлөөг хэмждэг.

2016 онд 104 улсын хувьд хөрөнгө оруулалт таталтын индексийг тооцоолсон бөгөөд Монгол Улс 81 дүгээр байранд эрэмбэлэгдсэн байна. 2012 онд Монгол Улс нь 96 орноос 31 дүгээр байрт эрэмбэлэгдэж байсан бол үүнээс хойш бодлогын ойлголтын индекс ба ашигт малтмалын боломжийн индексүүд нь зэрэг буурсаар байгаа тул Монгол Улсын эрэмбэ ухарсаар байгаа юм. Тухайлбал, 2012 онд бодлогын ойлголтын индекс нь 96 орноос 78-д эрэмбэлэгдэж байсан бол 2016 онд 104 орноос 101-т эрэмбэлэгдэж байгаа бол 2012 онд ашигт малтмалын боломжийн индекс нь 96 орноос 1-д эрэмбэлэгдэж байсан бол 2016 онд 104 орноос 50-д эрэмбэлэгдэж байна. Ерөнхийдөө Монгол Улсын индексүүдийн эрэмбэ буурсаар байна.

Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн (2015) нь Монгол Улс уруу чиглэсэн ГШХО-ын урсгал буурч байгааг тайлбарлах 3 хүчин зүйл байгааг дурджээ. Тэдгээр нь уул уурхайн бүтээгдэхүүний үнийн бууралт, гадаадын хөрөнгө оруулагчидтай хийсэн маргаан болон бодлогын шийдвэрийн тогтворгүй байдал зэрэг юм. Уул уурхайн бүтээгдэхүүний үнийн бууралт нь маш олон хүчин зүйлээс шалтгаалж байхад гадаадын хөрөнгө оруулагчидтай хийсэн маргаан ба бодлогын шийдвэрийн тогтворгүй байдал нь хөрөнгө оруулалтын орчин болон Монгол Улсын хөрөнгө оруулалтын эрэмбэ зэргээс өндөр хамааралтай байдаг.

Монгол улсын уул уурхайн голлох бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэлийн дэлхийн нийт үйлдвэрлэлд эзлэх хувь өчүүхэн бага тул уул уурхайн бүтээгдэхүүнүүдийн үнэ нь ГШХО-ын урсгалын өөрчлөлтөд нөлөөлөх гадаад хувьсагч юм. Монгол Улсын ГШХО-ын урсгал болон уул уурхайн бүтээгдэхүүний үнийг харьцуулахын тулд бид алт, зэс, төмрийн хүдэр болон нүүрсний үнийг ашиглан үнийн индексийг үүсгэсэн.


Энэ индекс нь алт, зэс, төмрийн хүдэр болон нүүрсний үнийн жигнэсэн дунджаар тодорхойлогдоно. Эдгээр бүтээгдэхүүний түүхэн үнийг ОУВС, Дэлхийн банкнаас авсан бол үнийн таамаглалыг Дэлхийн банк, ОУВС, Морган стэнли, АНУ-ын эрчим хүчний мэдээллийн агентлаг гэх зэрэг байгууллагуудын таамаг үнийн дунджаар авсан. Үнийн өөрчлөлтийг тусгахын тулд бүх бүтээгдэхүүний үнийг 2009 оны суурь үнэтэй харьцангуй байдлаар авсан. Бүх бүтээгдэхүүний хувьд суурь үнийн анализ хийснээр нэг индекс үүсэх ба энэ индекс нь уул уурхайн бүтээгдэхүүний үнийн индексийг боловсруулахад ашиглагдсан. Мөн Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тоон мэдээлэлд тулгуурлан бүтээгдэхүүн тус бүрийн хувийн жинг тооцоолсон (Үндэсний статистикийн хороо, 2016). Монгол улсын нүүрс, алт, төмрийн хүдэр болон зэсийн экспортын түүхэн тоон хэмжээнүүдийн нийлбэрийг олсон бөгөөд үүнийг зохистой жинг тооцоолоход ашигласан. Бүтээгдэхүүнүүдийн жин жил бүр хэлбэлзэж байгаа нь үнийн хөдөлгөөнийг илүү бодитой харуулж байна.

Доорх зураг нь ГШХО-ын урсгал болон уул уурхайн бүтээгдэхүүний үнийн индексийг харуулж байна. Дор харуулснаар ГШХО-ын урсгал болон уул уурхайн бүтээгдэхүүний үнийн хандлага нь ижил байгаа ба үнэ буурч байхад ГШХО-ын урсгал мөн адил буурч байна. Энэ хандлага нь

⁵ Энэ судалгаа нь 15 бодлогын хүчин зүйлүүдийн талаар менежер, гүйцэтгэх захирлуудаас асуулга авдаг.

бусад бараа экспортлогчид болон төрөл бүрийн судалгаануудад ажиглагддаг бөгөөд энэ нь уул уурхайн бүтээгдэхүүний үнэ болон ГШХО-ын урсгалын хөдөлгөөн нь төстэй болохыг баталж байна (Kose, 2002; Céspedes & Velasco, 2012; Fornero, Kirchner, & Yany, 2016).

Зураг 4. Уул уурхайн бүтээгдэхүүний индекс болон ГШХО-ын урсгал, 2009-2016



Эх сурвалж: Монгол Банк, ҮСХ, Дэлхийн Банк болон судалгааны багийн тооцоолол

Өмнө дурдсанчлан Монгол Улс уул уурхайн бүтээгдэхүүний үнэд нөлөөлж чадахгүй. Өөрөөр хэлбэл, ГШХО-ын өсөлт болон бууралт нь Монгол Улсаас хамаарахгүй. Тиймээс Монгол Улс нь эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, тодорхой бус байдлыг бууруулахын тулд өөрийн ГШХО-ын урсгалыг зүй зохистой зарцуулах хэрэгтэй. Үүний тулд Монгол Улс уул уурхайн бүтээгдэхүүний үнэ ирээдүйд өснө гэж найдаж суухын оронд хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах нь зүйтэй.

Хөрөнгө оруулагчид нь өөрсдийн хөрөнгө оруулалтын өгөөжийг таамаглагдахуйц хүлээн зөвшөөрч болохуйц байлгахыг хүсдэг тул бусад улс орнуудад хөрөнгө оруулалтын орчин нь ГШХО-ыг татахад голлох нөлөөг үзүүлдэг⁶. Хэрэв уул уурхайн баялаг ихтэй тухайн улсад хөрөнгө оруулалтын орчин таатай байвал уул уурхайн бүтээгдэхүүний үнэ буурч байсан ч ГШХО нь харьцангуй тогтвортой байж чаддаг байна. Дараах хүснэгтэд 2012-2016 оны Монгол болох Чили улсуудын хөрөнгө оруулалтын орчин болон ГШХО-ын цэвэр урсгалтай холбоотой индексүүдийн эрэмбийг харьцуулан харуулав. Энэ 2 улс нь уул уурхайн салбараас хүчтэй хамааралтай улсууд болно.

Хүснэгт 10. Монгол болон Чили улсуудын ГШХО-ын урсгал болон 3н индексүүд, 2012-2016

	ГШХО-ын цэвэр урсгал, тэрбум \$	Хөрөнгө оруулалт таталтын индексийн эрэмбэ	Бодлогын ойлголтын индексийн эрэмбэ	Ашигт малтмалын боломжийн индексийн эрэмбэ
Монгол				
2012	4.27	31/96	78/96	1/96
2013	2.06	80/112	95/112	51/112
2014	0.34	93/122	116/122	52/122
2015	0.09	85/109	94/109	59/109
2016	-4.20	81/104	101/104	50/104
Чили				
2012	30.56	11/96	18/96	8/96

⁶ Хөрөнгө оруулагчид нь зардал, эрсдэл, хүлээлт гэсэн 3н бэрхшээлээс зайлсхийх хандлагатай байдаг (OSCE, 2006).

2013	21.09	4/112	21/112	4/112
2014	24.01	9/122	22/122	6/122
2015	20.47	11/109	26/109	11/109
2016	12.23	39/104	35/104	49/104

Эх сурвалж: (Fraser Institute, 2016), Дэлхийн Банк

Монгол Улсын хөрөнгө оруулалт таталтын индекс буурсны гол шалтгаан нь төрийн бодлогын ойлголт муудаж байгаатай холбоотой юм. Тухайлбал, 2016 онд Монгол Улс бодлогын ойлголтын индексээр хамгийн доод байрыг эзэлсэн нь судалгаанд оролцогчдын ойлголт муудсантай холбоотой. Энэ нь маргаантай газрын нэхэмжлэл (+20 оноо), хамгаалалттай газар нутгийн талаарх тодорхой бус байдал (+19 оноо) болон хөдөлмөрийн чадвар ба ажиллах хүчний хүрэлцээ (+11 оноо) зэргээс шалтгаалжээ.

Доорх хүснэгт нь хөрөнгө оруулалтын орчныг харуулж байгаа. Ингэхдээ хүмүүсийн сайн мэддэг индексүүд болох Авлигын ойлголтын индекс (CPI), Эдийн засгийн эрх чөлөөний индекс (EFI), Дэлхийн банкны бизнес эрхлэхүйн индекс (DBI) болон Глобал инновацийн индексүүдийг (GII) ашиглалаа. Чилийн индексүүдийн эрэмбэ нь өндөр байгаа тул Монголтой харьцуулахад Чилийн хөрөнгө оруулалтын орчин нь таатай байна.

Хүснэгт 11. Хөрөнгө оруулалтын орчныг илэрхийлэх хамгийн их ашиглагддаг индексүүд, 2016

Хэмжүүр	Эрэмбэ	
	Монгол	Чили
Авлигын ойлголтын индекс (CPI) ¹	87/176	24/176
Эдийн засгийн эрх чөлөөний индекс (EFI) ²	129/180	10/180
Бизнес эрхлэхүйн индекс (DBI) ³	64/190	57/190
Глобал инновацийн индекс (GII) ⁴	55/128	44/128

Эх сурвалж: ¹ <https://www.transparency.org/country/SGP>, ² <http://www.heritage.org/index/ranking>, ³ <http://www.doingbusiness.org/rankings>, ⁴ (Cornell University; INSEAD; WIPO, 2017)

Латин Америкт байрладаг **Чили** улс нь хөрөнгө оруулагчдын хамгийн ихээр анхаарал хандуулдаг газруудын нэг юм. Учир нь Чили нь чөлөөт эдийн засагтай, маш сайн хөгжсөн институт ба хатуу хууль дүрэмтэй улс юм. Тэдний ГШХО-ыг татах, хамгаалах хууль эрх зүйн орчин нь цөөн тооны хязгаарлалтуудтай. Мөн Чилийн хөрвүүлэх, шилжүүлэх бодлогууд нь АНУ шиг өндөр хөгжилтэй улсуудынхтай ижил байдаг ба энэ нь тэдний маш сайн хөгжсөн хөрөнгийн зах зээл, харьцангуй ил тод зохицуулалтын системтэй холбоотой.

ГШХО-ыг татахад учирдаг гол саад бэрхшээлүүд нь авлига болон зөвшөөрөл авах үйл явц юм. 2016 онд Чили улс нь авлагын ойлголтын индексээр (CPI) 176 орноос 24 дүгээрт эрэмбэлэгдсэн ба энэ нь Латин Америкийн ихэнх улс орнуудтай харьцуулахад өндөр үзүүлэлт юм. Энэ нь авлигын дундаж төвшинтэй байгааг харуулж байна. Чилид бизнес эрхлэхийн тулд компани нь байгаль орчин болон хотын захиргааны бодлого болон өөр бусад бодлогуудад хамааралтай олон тооны зөвшөөрлийг авах шаардлагатай байдаг. Энэ үйл явцын үргэлжлэх хугацаа нь ГШХО татахад хүндрэл учруулдаг гол хүчин зүйлүүдийн нэг бөгөөд Чили улс нь бизнес эрхлэхүйн индексээр дэлхийн 190 орноос 57д эрэмбэлэгддэг байна.

Монгол улс нь асар их ашигт малтмалын нөөц, Хятад улстай хил залгаа байдал, хөдөө аж ахуйн чадавх зэргээс шалтгаалан дунд болон урт хугацаанд хөрөнгө оруулагчдын анхаарлыг татдаг. Гэхдээ богино хугацаанд олон улсын зах зээл дээр ашигт малтмалын түүхий эдийн үнэ бага байгаа, дэд бүтэц хангалтгүй, бодлогын тогтворгүй байдал, гадаадын хөрөнгө оруулагчид, эдийн

засгийн олон талт байдалд хариу үйлдэл үзүүлэхгүй байх зэрэг нь хөрөнгө оруулагчдад Монгол Улсыг хөрөнгө оруулалтын тааламжгүй орчин гэж үзэхэд хүргэж байна.

2016 онд Чили улс нь өмнө нь дурдсан олон индексүүдээр Монгол Улсаас дээгүүр эрэмбэлэгдсэн ба энэ нь Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчин нь Чили улсынх шиг тааламжтай бус байгааг илтгэж байна. Тухайлбал, 2016 онд авлигын ойлголтын индексээр Чили улс нь 176 орноос 24-д байхад Монгол Улс 87-д бичигдэж байсан. Бизнес эрхлэхүйн индексээр Чили улс 57-д байхад Монгол Улс 65-д бичигдэж байсан. Чили улсад хөрөнгө оруулж бизнес эрхлэхэд маш олон шаардлагуудыг хангах ёстой байдаг боловч хөрөнгө оруулагчдад Чилийн хөрөнгө оруулалтын орчин нь Монгол улсаас илүү тааламжтай байдаг.

Үүнээс харахад хөрөнгө оруулалтын орчин нь байгалийн баялагтай улс орнуудад уул уурхайн бүтээгдэхүүнүүдийн үнэтэй ижил чухал байдаг бол уул уурхайн баялаггүй улс орнуудад бүр ч илүү чухал болох нь харагдаж байна. Сүүлийн жилүүдэд уул уурхайн баялаггүй улсууд хөрөнгө оруулалтын таатай орчноороо ГШХО-ыг татсаар байна⁷. 2014 онд Economist Intelligence Unit (EIU) нь улс орнуудыг хөрөнгө оруулалт, бизнесийн орчноор нь эрэмбэлсэн. Гэсэн хэдий ч эхний 3-т эрэмбэлэгдсэн улсууд нь уул уурхайн баялаггүй Сингапур, Швейцар, Хонконг гэсэн улсууд байсан бөгөөд эдгээр улс нь ГШХО-ыг маш ихээр татдаг.

Азийн бар 4 орны нэг болох Сингапурын эдийн засаг 1990 оноос хойш хурдацтай өссөн⁸ ба стратегийн 7 үе шатын дагуу амжилтад хүрсэн бөгөөд үе шат бүрд илүү их ГШХО-ыг татахын тулд илүү нээлттэй эдийн засгийг бие болгохыг эрмэлзэж байсан. Тан (1999) нь Сингапур улсад гадаадын хөрөнгө оруулагчдыг татдаг дараах хүчин зүйлүүд байгааг дурджээ:

- Улс төрийн тогтвортой байдал
- Засгийн газар болон бизнесүүдэд авлига байхгүй байдал
- Хуулийг дээдэлж буй байдал
- Засгийн газрын амлалтаа биелүүлж байгаа байдал

Эдгээр хүчин зүйл нь Сингапур улсад хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрэлдүүлдэг. Ихэнх шинжээчид улс орнуудын хөрөнгө оруулалтын орчныг тодорхойлохдоо Бизнес эрхлэхүйн индекс (DBI), Эдийн засгийн эрх чөлөөний индекс (EFI) гэх мэт индексүүдийг ашигладаг. Доорх хүснэгтэд 2016 оны хамгийн их ашиглагддаг 4 индексийн Сингапур улсын эрэмбийг харуулав. Авлигын ойлголтын индексийн(CPI) хувьд Сингапур улс 100 онооноос 84 оноо авч 176 орноос 7д эрэмбэлэгдсэн байна.

⁷ Хөрөнгө оруулалтын хамгийн таатай орчинтой 10 улсуудад Сингапур, Швейцар, Хонконг, Канад, Австрали, Швед, АНУ, Шинэ Зеланд, Финлянд, болон Дани зэрэг улсууд багтаж байна (The Economist Intelligence Unit, 2014).

⁸ 1993 онд Дэлхийн банк өөрийн судалгаанд дүгнэснээр нийтлэг, зах зээлд ээлтэй эдийн засгийн бодлого хэрэгжүүлснээр их хэмжээний хадгаламж төвлөрч, нөөцийн үр ашигтай хуваарилалт явагдаж улмаар эдийн засаг нь хурдацтай өссөн (Skousen, 1996).

Хүснэгт 12. Хамгийн их ашиглагддаг индексүүд болон эрэмбүүд, 2016

Хэмжүүр	Эрэмбэ		
	Сингапур ⁹	Швейцар ¹⁰	Хонконг ¹¹
Авлигын ойлголтын индекс (CPI)	7 of 176	5 of 176	15 of 176
Эдийн засгийн эрх чөлөөний индекс (EFI)	2 of 180	4 of 180	1 of 180
Бизнес эрхлэхүйн индекс (DBI)	2 of 190	31 of 190	4 of 190
Глобал инновацийн индекс (GII)	7 of 127	1 of 127	16 of 127

Эх сурвалж: <https://www.transparency.org/country/CHE>; <https://www.transparency.org/country/HKG>; <http://www.heritage.org/index/ranking>, <http://www.doingbusiness.org/rankings>, (Cornell University; INSEAD; WIPO, 2017);

Сингапуртай ижил төстэй улсууд болох Швейцар, Хонконг гэх улсуудад ижил хандлага ажиглагдсан ба тэдгээр нь: байгалийн нөөцийн хомс байдал, орон нутгийн институтын ил тод байдал, улс төрийн тогтвортой байдал, сайн тогтолцоо бүхий санхүүгийн зах зээлд нэвтрэхэд амар хялбар байдал, дэлхийн зэрэглэлийн дэд бүтэц, өндөр ур чадвартай, боловсролтой ажиллах хүчний хүртээмж зэрэг болно. Энэ төрлийн хөрөнгө оруулалтын орчин нь Монгол Улсынхаас ихээхэн өөр байгаа ба хөрөнгө оруулалтын орчин нь ГШХО-ын урсгалын өөрчлөлт болон ГШХО-ыг хэрхэн татах талаар тайлбарлаж чадахгүй юм.

Хүснэгт 13. Монгол улсын ГШХО-ын урсгал болон хамгийн их ашиглагддаг индексүүд, 2010-2016

	2010	2011	2012	2013	2014	2015	2016
ДНБ-ий өсөлт	6.4%	17.3%	12.3%	11.6%	7.9%	2.4%	1.0%
ГШХО, сая \$	1691.0	4571.0	4272.0	2060.0	337.0	94.0	-4156.0
Авлигын ойлголтын индекс (CPI) ¹²	27.0	27.0	36.0	38.0	39.0	39.0	38.0
Эдийн засгийн эрх чөлөөний индекс (EFI) ¹³	60.0	59.5	61.5	61.7	58.9	59.2	59.4
Бизнес эрхлэхүйн индекс (DBI) ¹⁴	58.7	58.8	60.0	61.8	63.2	66.6	67.3

⁹ 2016 онд Сингапурын ГШХО-ын урсгал 61.6 тэрбум \$ байсан бөгөөд азидаа Хятадын дараа 2т бичигдсэн (UNCTAD, 2017).

¹⁰ 2015 онд Швейцар улсын ГШХО 70.4 тэрбум \$-т хүрч европт 3-р байранд бичигдсэн бөгөөд 2016 онд -26.3 тэрбум \$ -т хүрч буурчээ(UNCTAD, 2017). Швейцар улс ГШХО-г эдийн засгийн өсөлтийн чухал хэсэг гэж үздэг тул гадаадын хөрөнгө оруулалтад маш нээлттэй ханддаг. Гадаадын хөрөнгө оруулалт нь томоохон саад бэрхшээлүүдээр хязгаарлагдахгүй. Гадаадын хөрөнгө оруулагчид, гадаадын хөрөнгө оруулалтын талаар ялгаварлан гадуурхах үзэгдэл байдаггүй (U.S. Department of State, 2014).

¹¹ Хонконг нь дэлхийд АНУ-ын дараа ордог хоёр дах том ГШХО хүлээн авагч улс юм (UNCTAD, 2016). Хонконг улсын хувьд ГШХО нь шинэ болон сайжруулсан бүтээгдэхүүн, үйл ажиллагаа, дизайн болон менежментийн арга хэрэгслийг нэвтрүүлэх хэрэгсэл болдог тул ГШХО-ыг ихээхэн дэмждэг байна. Үндсэндээ Хонконг улсад эдийн засаг дахь ГШХО-ыг хязгаарлах, хориглох, нөхцөл тавих хууль тогтоомж болон туршлага байдаггүй. Хонконгд дотоодын үйлдвэрүүд татаас авдаггүй бол гадаадын хөрөнгө оруулагчдад ямар нэгэн квот, бонд, хадгаламж гэх мэт ижил төстэй хязгаарлалтууд байдаггүй. 2016 онд Хонконгд үйл ажиллагаа явуулдаг 3731 компани бүртгэгдсэн бөгөөд үүнээс 766 нь АНУ, 659 нь Япон, 347 нь Их Британийн компани байсан.

¹² Авлигын ойлголтын индексийг 10 өөр байгууллагын 13 өөр судалгаа, үнэлгээний (Transparency International, 2010) тоон мэдээллийг ашиглан тооцоолдог бөгөөд 0-ээс 100 хооронд утга авдаг. Хэрвээ тухайн улс 50-с бага оноо авбал энэ нь авлига маш ихтэй байгааг харуулдаг бөгөөд 100 оноо авбал авлига огт байхгүй байгааг илтгэнэ.

¹³ Энэ индекс нь 186 орны эдийн засгийн чөлөөт байдлыг хэмждэг бөгөөд 12 тоон болон чанарын хүчин зүйлс дээр тулгуурладаг. Эдгээр нь үндсэн 4 хэсэгт хуваагддаг (худалдааны эрх чөлөө, бизнесийн эрх чөлөө, хөрөнгө оруулалтын эрх чөлөө, өмчийн эрх). 2017 онд олон улсын дундаж эдийн засгийн эрх чөлөө нь 0.2 нэгжээр өсөж 60.9 (0-100 онооноос) хүрсэн байна.

¹⁴ Бизнес эрхлэхүй судалгаа нь 190 орны бизнесийн зохицуулалт, өмчийн эрхийн хамгаалалтын талаарх олон тооны үзүүлэлтүүдийг боловсруулж, үзүүлэлтүүдийг харьцуулдаг. Энэ нь 11 үйл ажиллагаанд нөлөөлж буй зохицуулалтыг хэмждэг: бизнес эхлүүлэх, барилгын зөвшөөрөл авах, цахилгаан эрчим хүчний зөвшөөрөл авах, зээл авах, хөрөнгө оруулагчдыг хамгаалах, татвар төлөх, хил дамнан худалдаа хийх, гэхээ байгуулах, төлбөрийн чадваргүй байдлыг

Глобал инновацын индекс (GI)¹⁵		27.8	33.4	35.0	35.8	37.5	36.4	35.7
Өрсөлдөх индекс (CI)¹⁶	чадварын	3.8	3.9	3.9	3.8	3.8	3.8	3.8
Дэлхийн индекс (WGI)¹⁷	засаглалын	-0.213	-0.192	-0.211	-0.194	-0.083	-0.118	-

Эх сурвалж: Heritage Foundation, World Economic Forum, World Bank, Transparency International, and Cornell University, INSEAD and WIPO¹⁸ and Bank of Mongolia

Дүгнэж хэлбэл Монгол Улсын одоо болон өнгөрсөн үеийн ГШХО-ын урсгалыг тодорхойлох гол хүчин зүйл бол уул уурхайн бүтээгдэхүүний үнэ. Энэ хандлага нь бусад эрдэс баялгаар баян улсуудад ажиглагддаг. Гэсэн хэдий ч өндөр хөгжилтэй орнууд нь эрдэс баялгаар төдийлөн баян биш байдгаас хөрөнгө оруулалтын орчин нь ГШХО-ыг татах гол хүчин зүйл болдог. Монголын хөрөнгө оруулалтын орчин тааламжтай бус бөгөөд энэ нь Монгол Улс хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэхийн тулд уул уурхайн бүтээгдэхүүний үнэ ирээдүйд өснө эсвэл тогтвортой байна гэж таамаглахаас илүү хөрөнгө оруулалтын орчноо сайжруулах шаардлагатай гэдгийг харуулж байна.

шийдвэрлэх болон хөдөлмөрийн зах зээл. Бусад орнуудад DBI нь ГШХО -ын ялгаатай байдлыг тайлбарлаж чадна. Anderson & Gonzalez, (2012) нар DBI ийн эрэмбэ өндөр байгаа нь бодит эдийн засагт ажлын байр, шинэ технологи, үйлдвэрлэл болон бусад ашигтай зүйлсийг бие болгодог хөрөнгө оруулалттай холбоотой гэж үзжээ.

¹⁵ Глобал инновацын индекс нь 0-100 хооронд утгатай, улс орнуудыг жил бүр инноваци, амжилт болон тэдний чадавхаас хамааран эрэмбэлдэг.

¹⁶ Өрсөлдөх чадварын индекс нь 138 улс орны (заримдаа 140) тоон мэдээнд суурилдаг ба улс орны удирдлагуудад тэдний бүтээмж болон хөгжил цэцэглэлтийн талаар ойлголтыг өгдөг. Олон улсын өрсөлдөх чадварын тайланд дурдсанаар нэг улсын эдийн засгийн нээлттэй байдал буурснаар эдийн засаг өсөх болон хөгжил цэцэглэлтийн боломж буурна.

¹⁷ Дэлхийн засаглалын индекс нь 200 гаруй улс орнуудыг хамаадаг бөгөөд 1996 оноос хойш 6 хэмжээст засаглалын үзүүлэлтийг хэмжиж байна: covers over 200 countries and territories, measuring six dimensions of governance starting in 1996: Дуу хоолой ба хариуцлага тооцолт, Улс төрийн тогтвортой байдал ба хүчирхийллээс ангид байх, Засгийн газрын үр ашиг, Зохицуулалтын чанар, Хуулийн хэрэгжилт ба Авлигын хяналт (Kraay, Kaufmann, & Mastruzzi, 2010). Эдгээр индексүүд нь -2.5-аас 2.5 -ын хооронд утга авдаг. Тухайн улсын индекс 2.5 байвал засаглалын чанар маш сайн байгааг илтгэнэ.

¹⁸ World Intellectual Property Organization

ГШХО-ын ТӨЛӨВ

Тус судалгааны баг нь ГШХО-ын урсгалд суурилан Монгол Улсын эрэлт болон нийлүүлэлтийг таамаглалаа. Эрэлт нь томоохон төслүүдээс хамааралтай байдаг ба эдгээр төсөлд их хэмжээний санхүүжилт шаардагддаг тул эдгээрийг Монгол Улсын засгийн газар санхүүжүүлдэг. Нийлүүлэлт нь уул уурхайн бүтээгдэхүүний үнэ гэх мэт тодорхой хүчин зүйлүүдээс шалтгаалдаг.

Монгол Улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд хэд хэдэн төслийг төлөвлөсөн¹⁹. Үйл ажиллагааны төлөвлөгөөнд уул уурхайтай холбоотой хэд хэдэн төсөл байгаа. Тухайлбал: ²⁰

- Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулна.
- Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг дэмжинэ.
- Шингэрүүлсэн түлш, шатах тослох материалын үйлдвэр байгуулах ажлыг бодлогоор дэмжинэ²¹.
- Металл хийц, угсралтын үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

Монгол Улсын засгийн газраас 2016-2020 онд эрчим хүч, зам тээврийн салбарт дараах төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Эрчим хүчний салбарт:

- Цахилгаан станцуудын одоогийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
- Өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний хэрэглээг хангах зорилгоор эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийг байгуулна.
- Таван Толгойн цахилгаан станцыг барина.
- Шивээ-Овоо, Тэвшийн говь болон бусад нүүрсний ордыг түшиглэн экспортын зориулалттай том чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам барих төслийг эхлүүлнэ.
- Аймгийн төвүүд болон томоохон хот, суурин газарт дулааны станц, шугам сүлжээг шинээр барих, өргөтгөх ажлыг хэрэгжүүлнэ.

Зам тээврийн салбарт:

- Авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын сүлжээг өргөтгөж, бүх аймгийн төвийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбож дуусгана.
- “Оюу-Толгой-Гашуун сухайт”, “Хөөт-Бичигт”, “Таван толгой-Гашуун сухайт”, “Шивээ хүрэн -Сэхэ”, “Зүүнбаян- Ханги”, “Эрдэнэт-Овоот” чиглэлийн төмөр замын сүлжээг барина.
- Хөшигтийн Хөндийд шинэ тээвэр логистикийн төв байгуулна.
- БНХАУ-ын Тяньжин хотын Дунзяны чөлөөт боомт бүсэд тээвэр логистикийн төвийг байгуулна.

¹⁹ Энэ нь 5 бүлэгтэй: 1. Эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлого, 2. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого, 3. Нийгмийн бодлого, 4. Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого, 5. Засаглалын бодлого (Монгол Улсын Их хурал, 2016а).

²⁰ Уул уурхайн салбарын төслүүдийн зорилтууд нь хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, тогтвортой хөгжлийг хангах болон уул уурхайн дэлхийн зах зээл дэх Монгол Улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх юм.

²¹ Эдгээр төсөл нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан боловч санхүүжилт, төслийн хэрэгжих хугацаа гэх мэт зүйлс тодорхойгүй байна.

- Баянзүрх, Яармаг, Сонсголонгийн гүүр болон Улаанбаатар-Налайх чиглэлийн автозамыг шинээр барина

2016-2020 оны Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс гадна Монгол Улсын Их хурлаас “Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Үзэл Баримтлал 2030”-ыг баталсан²². Энэхүү урт хугацааны төлөвлөгөөний дагуу Монгол Улс нь 2030 он гэхэд дараах зүйлсийг хэрэгжүүлсэн байна (Хавсралт дахь хүснэгт Х4-өөс нарийвчилсан хэрэгжилтийг харна уу).

- Нэг хүнд ногдох үндэсний нийт орлогыг 17500 ам.долларт (2014 оны суурь түвшин 4166 ам.доллар байсан) хүргэх бөгөөд нэг хүнд ногдох орлогоороо дундаас дээш орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрнэ.
- 2016-2030 оны хооронд эдийн засгийн жилийн дундаж өсөлтийг 6.6%-тай байлгана.
- Бизнес эрхлэлтийн үзүүлэлтээр дэлхийд эхний 40, өрсөлдөх чадварын үзүүлэлтээр эхний 70 орны нэг болно.

Эдгээр тогтвортой хөгжлийн зорилтыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд хөдөө аж ахуй, аж үйлдвэр, зэс боловсруулах, нүүрс, нефть-хими, хар төмөрлөгийн үйлдвэрлэл, уул уурхайн олборлох салбарын хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгч, эрчим хүч, дэд бүтцийн салбарыг түрүүлж хөгжүүлнэ. Үүнээс гадна Засгийн газраас ГШХО болон дотоодын хөрөнгө оруулалтыг татах замаар эдийн засгаа үргэлжлүүлэн өргөжүүлэхэд чиглэсэн бодлогыг баримтална. Засгийн газрын зорилго нь хөрөнгө оруулагчдыг татварын хөнгөлөлт, чөлөөлөлт зэрэг бүх талаар дэмжих замаар хөрөнгө оруулалтын орчныг нэмэгдүүлэх юм.

Дор жагсаасны дагуу, үйл ажиллагааны төлөвлөгөө болон урт хугацааны төлөвлөгөөнд олон тооны төслүүдийг төлөвлөсөн боловч санхүүжилт тодорхой бус байгаа. Уул уурхай, эрчим хүч, зам, тээврийн салбарууд дахь эдгээр төсөлд²³ маш их хэмжээний санхүүжилт шаардлагатай байгаа.

Хүснэгт 14. Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Үзэл Баримтлал 2030-д тусгагдсан гол үйл ажиллагаа

Салбар	2016-2020	2021-2025	2026-2030
Уул уурхай	Уул уухайн салбар дахь тогтвортой хөрөнгө оруулалтын орчныг бүрдүүлэх, байгаль орчинд ээлтэй дэд бүтэц болон тээвэрлэлтийн сүлжээг хөгжүүлэх, говийн бүсэд өндөр хүчин чадалтай цахилгаан станцыг байгуулах	Усан хангамжийн эх үүсвэрүүдийг найдвартай хангах төслүүдийг хэрэгжүүлэх, уул уурхайн томоохон төслүүдийн бүрэн ажиллагааг хангах	Уул уурхайн томоохон төслүүдийг эхлүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх
Эрчим хүч, Дэд бүтэц	Улсын нийт эрчим хүчний эрэлтийн 85%-ийг дотоодоосоо хангадаг болох	Улсын нийт эрчим хүчний эрэлтийн 90%-ийг дотоодоосоо хангадаг болох	Улсын нийт эрчим хүчний эрэлтийн 90%-ийг дотоодоосоо хангадаг болох, эрчим хүч экспортлогч орон болох

²² Энэ хөтөлбөр нь дотроо богино хугацааны (2016-2020), дунд хугацааны (2021-2025), урт хугацааны (2026-2030) гэсэн 3 хэсэгтэй.

²³ Эдгээр төсөл нь хувийн сектор (дотоод ба гадаад) болон Засгийн газраас санхүүжигдэх боломжтой.


	Нийт эрчим хүчний хэрэглээн дэх сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 20%-д хүргэх, цөмийн эрчим хүчний станцын бэлтгэл ажлыг эхлүүлэх	Нийт эрчим хүчний хэрэглээн дэх сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 25%-д хүргэх, цөмийн эрчим хүчний станцын бэлтгэл ажлыг дуусгах	Нийт эрчим хүчний хэрэглээн дэх сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 30%-д хүргэх, цөмийн эрчим хүчний станцын эрчим хүчийг ашиглаж эхлэх
	Замын үүд, Хөшигтийн Хөндий, Алтанбулагт тээвэр логистикийн төвүүдийг байгуулах	Уул уурхай, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбаруудад түшиглэсэн тээвэр, логистикийн төвүүдийг байгуулах, ашиглах	Шинэ тээвэр логистикийн төвүүдийг хөгжүүлэх
	1600км хатуу хучилттай замыг барих	800км хатуу хучилттай замыг барих	470км хатуу хучилттай замыг барих
	Ухаа худаг- Гашуун сухайт чиглэлийн төмөр замыг барьж, ашиглах	Эрдэнэт-Овоот, Богд хаан чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтыг дуусгах	Бүс нутгууд дахь төмөр замын бүтээн байгуулалтыг дуусгах
	Эрдэнэт-Овоот, Богд хаан чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтыг ажлыг эхлүүлэх	Бүс нутгууд дахь төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх	Үндэсний агаарын тээврийн сүлжээг өргөтгөх
	Хөшигтийн хөндийн олон улсын нисэх буудлын бүтээн байгуулалтыг ажлыг дуусгах	Үндэсний нисэхийн нөөц буудал байгуулах, орчин үеийн нийтийн тээврийн шинэ тогтолцоог Улаанбаатар хотод бие болгох	Бүс нутгийн агаарын тээврийн транзит төвийг байгуулах
	Улсын төсвийн алдагдлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 2%-д хүргэх.	Улсын төсвийн алдагдлыг арилгах	-
Макро эдийн засгийн бодлого			

Эх сурвалж: (Монгол Улсын Их хурал, 2016с)

Эдгээр том төсөл дэх Засгийн газрын үүргийг нарийн тодорхойлохын тулд, бид 2017 оны төсвийн тодотголыг судаллаа²⁴. Улсын нийт төсвийн тодотголд улсын төсвийн зарлага 8.7 их наяд төгрөг, орлого 6.02 их наяд төгрөг, алдагдал 2.7 их наяд төгрөг байсан. Улсын төсвийн алдагдал нь дараагийн 3 жилд 2 орчим их наяд төгрөг байх хандлага ажиглагдаж байгаа ч үүнийг жил бүр бууруулахын төлөө ажиллана.

²⁴ 2016 оны 11 сард УИХ-с 2017 оны улсын төсвийг баталсан (Монгол Улсын Их хурал, 2016b) бөгөөд 6 сарын дараа тодотгол хийсэн.

Зураг 5. 2017 оны улсын төсвийн тодотгол




* -батлагдсан төсөв; эх үүсвэр: (Монгол Улсын Их хурал, 2017)

Алдагдалтай батлагдсан төсөв нь улсын төсвийн капиталын зардлыг бууруулах хандлагатай байгаа. Тухайлбал 2017 онд Засгийн газраас төсвийн тэнцлийг хадгалахын тулд капиталын зардлаа бууруулсан. 2017 онд нийт улсын төсвийн зарлагад эзлэх капиталын зардал 17% байхаар батлагдсан бол 2017 оны сүүлч гэхэд ерөнхийдөө буурах хандлагатай байна. Гэсэн хэдий ч дээр дурдсан төслүүд капиталын зардалд тусгагдаагүй байна. Үүнээс харахад дээрх төлөвлөсөн төслүүд нь Засгийн газраас санхүүжигдэхгүй болохыг харуулж байгаа ба оронд нь хувийн сектороос санхүүжилт авах боломжтой. Засгийн газраас нэмэгдэл ГШХО-ын урсгалаар үйл ажиллагааны төлөвлөгөө, урт хугацааны төлөвлөгөөнд заасан төслүүдийг санхүүжүүлнэ хэмээн төлөвлөж байж болох юм.

Монголд ГШХО-ын урсгалыг тодорхойлох гол хүчин зүйл нь уул уурхайн бүтээгдэхүүний үнэ байдаг. Тиймээс ГШХО нэмэгдэх эсэх нь бүхэлдээ үнийн таамаглалаас хамаарч байна. Ойрын хэдэн жилүүдэд уул уурхайн бүтээгдэхүүний үнэ харьцангуй тогтвортой байх төлөвтэй байгаа ба ГШХО-д нөлөөлөх бусад гадаад хүчин зүйл гарч ирэхгүй л бол ГШХО-ын урсгал нь уул уурхайн үнийн таамаглалын дагуу харьцангуй тогтвортой байх болно.

Зураг 6. Үнийн индексийн таамаглал, 2017-2020 он



Эх сурвалж: Судалгааны багийн тооцоолол, ДБ, ОУВС, Морган станлэй, СМЕ групп, Оюу толгойн таамаглал

Хөрөнгө оруулалтын орчин тааламжгүй байгаагаас төслүүдийн амжилттай хэрэгжих эсэх нь ГШХО-ын урсгал тухайлбал уул уурхайн бүтээгдэхүүнүүдийн үнээс хамааралтай байна. 2020 он хүртэл уул уурхайн бүтээгдэхүүнүүдийн үнэ тогтвортой эсвэл дунд зэргийн өндөр өсөлт

үзүүлэх хандлагатай байна. Монгол улсын хувьд уул уурхайн бүтээгдэхүүний үнийн түвшинд нөлөөлж чадахгүй ч эдгээр үнийн өсөлт нь ГШХО-ын урсгалыг нэмэгдүүлэх болно.

Оюу Толгойн төслийн гүний уурхайн бүтээн байгуулалтад маш их хэмжээний ГШХО орж ирэхээр хүлээгдэж байгаа боловч энэхүү ГШХО-ын зорилго нь тодорхой байгаа тул энэ хөрөнгө оруулалтаас ямар ч мөнгө Засгийн газрын төлөвлөгдсөн төслүүдэд зарцуулагдахгүй. Гэсэн хэдий ч Оюу Толгойд хийгдэх их хэмжээний хөрөнгө оруулалтыг дагасан нэмэлт хөрөнгө оруулалт орж ирж болзошгүй бөгөөд үүнээс төлөвлөгдсөн төслүүдийг санхүүжүүлж болох юм.

2017 онд ОУВС Монгол улсын эдийн засгийг сайжруулахаар 434.3 сая ам.долларын дэмжлэг үзүүлэх өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг баталсан. Нийт санхүүжилтийн багц нь 5.5 тэрбум ам.доллар бөгөөд Азийн хөгжлийн банк(АХБ), Дэлхийн банк, БНСАУ, Япон болон БНХАУ-аас санхүүжүүлнэ. Энэ санхүүжилт нь тодорхой бус байдлыг бууруулахад голлох нөлөөг үзүүлэх бөгөөд Монгол улсын нэр төр сайжирч хөрөнгө оруулагчдын анхаарлыг татахад туслах юм.

Монгол Улсын парламентын баталсан хөтөлбөр болон төлөвлөгөөнд тусгагдсанаар энэ хөтөлбөрийн зорилго нь илүү их ГШХО-ыг татах юм. Хэдий тийм ч, өнгөрсөн, одоо болон ойрын ирээдүйн ГШХО-ын урсгалын хэлбэлзэл нь ерөнхийдөө уул уурхайн бүтээгдэхүүний үнийн хэлбэлзлээр тайлбарлагдаж байна. Дэлхийн нийт уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд Монгол улс маш бага хувь нэмэртэй байдаг тул эдгээр уул уурхайн бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэлд Монгол улс нөлөөлж чадахгүй. Гэсэн хэдий ч Монгол улс өөрсдийн зохицуулалт болон институтын орчныг сайжруулахад анхаарах юм бол хөрөнгө оруулалтын орчин мэдэгдэхүйц сайжирч, ГШХО-ыг татахад ихээхэн нөлөөлнө.

ДҮГНЭЛТ

ГШХО-ын нөлөөний талаар олон үзэл байдаг хэдий ч голлох 2 үзэл баримтлал байдаг. Эхний үзэл баримтлал нь ГШХО-ын орох урсгал нь хүмүүн капитал, улс төрийн орчны чанар болон эдийн засгийн өсөлтийг дэмждэг гэж үздэг. Нөгөө үзэл нь хөгжиж буй орнуудад ГШХО-ын орох урсгал нь урт хугацаанд ажилгүйдэл, хэт хотжилт болон орлогын тэгш бус байдлыг нэмэгдүүлдэг гэж үздэг.

ГШХО-ын орох урсгал болон хөрөнгө оруулалтын орчны хооронд ач холбогдол бүхий эерэг хамаарал байдаг ба энэ нь ихэнх орнуудад ажиглагддаг. Тийм боловч Монгол улс дахь ихэнх судалгаанууд нь ГШХО-ын орох урсгал болон эдийн засгийн өсөлтийн хоорондын хамаарал дээр төвлөрдөг. Монголын хувьд ГШХО-ын орох урсгал нь уул уурхайн салбар тэр дундаа томоохон уул уурхайн төслүүдтэй ихээхэн хамааралтай байдаг. Харамсалтай нь сүүлийн жилүүдэд Монгол Улсын ГШХО-ын орох урсгал нь тогтвортой буурч байгаа ба 2016 онд сөрөг 4.2 тэрбум ам.долларт хүрчээ. Үүний гол шалтгаанууд нь уул уурхайн бүтээгдэхүүний үнийн бууралт ба зохицуулалт болон институтийн орчны таагүй байдал байсан.

2010 болон 2015 он дахь ГШХО-ын орох урсгалын нөлөө нь ялгаатай байгаа ба энэ нь ГШХО-ын урсгал нь салбаруудад хэрхэн хуваарилагдаж байгаа болон үүний хэдэн хувь нь дотоодын зах зээлд шингэж байгаагаас шалтгаална. ГШХО-ын орох урсгал нь дотоодын зах зээлд илүү шингэдэг тул ГШХО-ын орох урсгалын нөлөө нь илүү ач холбогдолтой байдаг. Өнгөрсөн болон одоогийн байдлаар ГШХО-ын орох урсгалын 70-аас илүү хувь нь капиталыг илүү ихээр хэрэглэдэг уул уурхайн салбарт хуваарилагдаж байна. Тиймээс Монгол Улс уул уурхайн салбарт ашиглагдах машин механизмыг дотооддоо үйлдвэрлэхийн тулд аж үйлдвэрийн салбараа хөгжүүлэхэд төвлөрөх шаардлагатай юм.

Өнгөрсөнд болон одоогоор Монгол Улсад ГШХО-ын орох урсгалыг тодорхойлж байгаа гол зүйл нь уул уурхайн бүтээгдэхүүний үнэ юм (Зураг 4). Монгол Улсын хувьд ГШХО-ын орох урсгал буурч байгааг хөрөнгө оруулалтын орчин дангаар тайлбарлаж чадахгүй байна. Гэсэн хэдий ч уул уурхайн баялаг хомс өндөр хөгжилтэй орнуудад хөрөнгө оруулалтын орчин нь ГШХО-ыг татахад голлох үүрэгтэй байдаг. Ирээдүйд Монгол Улс нь экзоген бөгөөд хэт их савлагаатай уул уурхайн бүтээгдэхүүний үнээс хамаараад байгаа ГШХО-ыг татахдаа уул уурхайн баялаггүй өндөр хөгжилтэй орнууд шиг хөрөнгө оруулалтын орчныг бүрдүүлэх хэрэгтэй.


Монгол Улсын Засгийн газар албан ёсны төлөвлөгөө, хөтөлбөрт тусгагдсан уул уурхай, эрчим хүч, дэд бүтцийн төслүүдийг эхлүүлж, хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Энэ төслүүд нь Монгол улсад орох ГШХО-ын урсгалын асар их хэмжээний эрэлтийг үүсгэнэ. Эдгээр төлөвлөгөө болон төслийн гол зорилго нь ойрын ирээдүйд эдийн засгийн хүндрэлийг даван туулах, төслүүдийг санхүүжүүлэхийн тулд ГШХО-ыг татахад оршиж байна. Өнгөрсөн болон одоогийн хандлагаас харахад ГШХО-ын хэлбэлзэл нь ерөнхийдөө уул уурхайн бүтээгдэхүүний үнээс шалтгаалж байна. Хэдий тийм ч Монгол улс нь дэлхийн зах зээл дэх уул уурхайн үйлдвэрлэлийн маш бага хувийг эзэлдэг тул уул уурхайн бүтээгдэхүүний үнэд нөлөөлж чадахгүй билээ. Тиймээс Монгол Улсын хувьд ойрын ирээдүйд ГШХО-ыг шууд татах зүйлийг хийж чадахгүй тул ГШХО-ын урсгалын уул уурхайн бүтээгдэхүүний үүнээс хамааралтай байдлыг бууруулахыг хичээх хэрэгтэй. Монгол Улсын засгийн газраас ирээдүйд ГШХО-ын урсгалыг шууд нэмэгдүүлэхийн тулд хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахыг зорьж байна.

ХАВСРАЛТ

Шигтгээ 1. Оюу Толгойн хэтийн төлөв

Туркойз Хилл Рэсурс компани хөрөнгө оруулагчдад 2025 оны төгсгөл гэхэд Оюу Толгойн зэс болон алтны үйлдвэрлэл харгалзан 320% болон 450%-аар тус тус өснө гэж мэдэгдсэн (The Mongolian Mining Journal, 2017).

Зэс болон алтны хүлээгдэж буй үйлдвэрлэл



Тэмдэглэл: Алтны үе шат – 2019-2021 онд 4 зэрэг; Эх сурвалж: (The Mongolian Mining Journal, 2017).

Доорх хүснэгтэд Оюу Толгойн 4 дэх үеийн хөгжүүлэлт болон зардлын төлөвлөгөөг²⁵ харууллаа. Энэ хүснэгтэд Монгол Улсад хийгдэх үйл ажиллагаа, далд уурхайн бүтээн байгуулалтын зардал болон Монгол Улсын Засгийн газарт төлөх төлбөр зэргийг багтаасан байгаа.

Оюу Толгойн далд уурхайн хөгжүүлэлт болон зардлын төлөвлөгөө, 2016-2022

	2016	2017	2018	2019	2020	2021	2022	Total
Далд уурхайн хөрөнгө оруулалтын капитал	0.3	1.1	1	1.1	0.7	0.5	0.1	4.8
Нийт капитал	0.4	1.2	1.1	1.3	1.2	1	0.6	6.8
Дотоодын үйл ажиллагааны зардал	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.7	4.3
Дотоодын капиталын зардал	0.2	0.5	0.4	0.5	0.4	0.4	0.2	2.6
Монгол Улсын Засгийн газарт төлөх шууд төлбөр	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.4	2.2
Монгол улс дахь шууд зарлага	1.1	1.4	1.3	1.4	1.3	1.3	1.3	9.1

Эх сурвалж: Оюу Толгойн далд уурхайн хөрөнгө оруулалтын хөгжил болон санхүүжилтийн төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн газар ба Рио Тинто, хуудас.5

²⁵ Сүүлийн жилүүдэд урьдчилан таамаглагдах боломжгүй хүчин зүйлс ялангуяа улс төрийн тогтворгүй байдлаас шалтгаалан үйл ажиллагааны гүйцэтгэл нь төлөвлөлтөөс ялгаатай байсан.

Шигтгээ 2. Монгол Улсын хөрөнгө оруулалтын хууль

Зохицуулалт болон хөрөнгө оруулалтын орчны нэг хэсэг нь хууль юм. Монгол Улсын Их хурал 2013 онд Хөрөнгө оруулалтын хуулийг баталсан (Монгол Улсын Их хурал, 2013). Энэ шинэ хууль нь хөрөнгө оруулагчдад таатай орчныг бүрдүүлэх зорилготой юм. Энэ хуулийн зарим үзэл баримтлалаас:

- Дотоод болон гадаадын хөрөнгө оруулагчид аль аль нь нийтлэг хуулийн хүрээнд зохицуулагдах ба Монгол Улсын Засгийн газар нь хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаална.
- Хуулийн дагуу гадаадын хөрөнгө оруулагчид нь Монгол улсад компани байгуулахын тулд зөвшөөрөл авах шаардлагагүй бөгөөд Зохиогчийн эрх, Улсын бүртгэлийн ерөнхий газарт шууд бүртгэгдэнэ.

Энэ хууль нь гадаадын хөрөнгө оруулалтын орох урсгалыг нэмэгдүүлэх үндсэн зорилготой ба гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихдээ 2 сувгаар дамжуулан дэмжинэ: татвар болон татварын бус арга.

Татварын хөнгөлөлтийн хувьд барилгын материал, газрын тос олборлолт, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, нано технологи, эрчим хүч болон төмөр замын барилга зэрэг онцгой салбаруудад үйл ажиллагаа явуулж эхэлбэл Монгол Улсын Засгийн газраас татварын тогтвортой байдлыг хангах, татварын хөнгөлөлтийг үзүүлнэ. Тухайлбал импортлогдсон техник болон тоног төхөөрөмж нь импортын татвар болон нэмэгдэл өртгийн татвараас чөлөөлөгдөнө.

Татварын хөнгөлөлтөөс бусад урамшууллын хувьд гадаадын хөрөнгө оруулагчид нь газрыг 60 хүртэлх жил эзэмших, ашиглах эрхтэй ба үүнийг 40 хүртэлх жил сунгах боломжтой байдаг. Мөн дэд бүтэц, аж үйлдвэрлэл, шинжлэх ухаан болон боловсролын салбарт үйл ажиллагаа явуулбал Монгол Улсын Засгийн газраас хөрөнгө оруулагчдыг гадаадаас ажиллах хүчийг импортлохтой холбоотой төлбөрөөс чөлөөлнө²⁶. Засгийн газар экспортын баримжаатай дэвшилтэт технологийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжиж, санхүүжилтийн баталгаагаар хангана.

²⁶ Монгол Улсын хөдөлмөрийн хуулиар гадаадын ажиллах хүчнийг хөлслөх хүсэлтэй байгаа ажил олгогч Хөдөлмөрийн яамнаас зөвшөөрөл авах ёстой. Хэрвээ зөвшөөрөл авах боломжгүй бол ажил олгогч нь гадаад ажилчин тус бүрт сар бүр ажлын байрны төлбөр төлөх ёстой. Монгол Улсын Засгийн газар гадаад ажилчдын квотыг 5%-80% -аар тогтоосон байдаг: ихэнх компаниудад 5% -ын квот тогтоосон байдаг; уул уурхай болон хайгуулын лицензтэй компаниудын хувьд квот 10% байдаг; газрын тос, байгалийн хий олборлодог компаниуд нь 80%-ын квоттой байдаг.

Сар тутмын ажлын байрны төлбөр нь эдийн засгийн салбар болон ажил эрхлэгчдийн гадаадын иргэн ажиллуулах квот зэргээс хамааран өөр өөр байдаг. Ерөнхийдөө төлбөр нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 нугалсантай тэнцүү байдаг(2017 оны 1 сарын 1-ы байдлаар 240,000 төгрөг). Гэсэн хэдий ч гадаадын ажилчдын тоо тогтоосон квотоос хэтэрсэл тухайн компани ажлын байрны төлбөрт хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 нугалсантай тэнцүү төлбөр төлөх ёстой.

Шигтгээ 3. Монгол дахь бизнес эрхлэх боломж

2016 онд Монгол улсын бизнес эрхлэхүйн индекс 190 орноос 56-д эрэмбэлэгдэж байсан бол 2017 онд эрэмбэ буурч 64-д хүржээ. Тухайн улсын индекс боломжит утгын хагасаас доогуур байвал тухайн улс нь хөрөнгө оруулахад эрсдэлтэйд тооцогддог. Дэлхийн Эдийн Засгийн форумын Зохион байгуулалтын санал асуулгын судалгаа (Executive Opinion Survey) нь оролцогчдоосоо Монгол Улсад бизнес эрхлэхэд хамгийн асуудалтай байдаг хүчин зүйлүүдийг асуудаг. 2016 оны судалгаанд тэдгээр гол асуудал нь засгийн газрын тогтворгүй байдал, санхүүжилт авах, гадаад валютын зохицуулалт болон бодлогын тогтворгүй байдал зэрэг байна. Эдгээр асуудал нь нийт судалгаанд оролцогчдын 10 болон түүнээс дээш хувийн саналыг авчээ. Хэрвээ Монгол Улс эдгээр асуудлыг шийдэж, сайжруулж чадвал ГШХО-ын орох урсгалыг нэмэгдүүлэх боломжтой юм.

Монгол Улсад бизнес эрхлэхэд хамгийн их асуудал дагуулдаг хүчин зүйлс, 2016



Эх сурвалж: (Дэлхийн банк, 2017а)

Бусад улсуудад тэр дундаа Сингапур, Хонконг болон Швейцарт тэдгээр бэрхшээл аль хэдийн шийдэгдсэн байдаг. Хөрөнгө оруулагчид бизнес эрхлэхэд хамгийн таатай орчинтой улсыг сонгодог тул Монгол Улс хөрөнгө оруулалтын орчинд илүү их төвлөрөх шаардлагатай байна. 2011 оноос хойш Монгол Улсын бизнес эрхлэхүйн индексийн утга болон хөрөнгө оруулалтын орчин сайжирсаар байгаа ч ГШХО-ын орох урсгал тогтвортой буурсаар байна. Магадгүй индексийн утга болон хөрөнгө оруулалтын орчин сайжирч байгаа нь ГШХО-ын орох урсгалыг нэмэгдүүлэхэд хангалтгүй байж болох юм.

Зураг Х 1. Үнийн таамаглалууд


Нүүрс (Эрчим хүчний нүүрс), \$/тонн



Төмрийн хүдэр, \$/тонн



Зэс, мянган \$/тонн



Алт, мянган \$/унц



Эх сурвалж: (Эдийн засгийн судалгаа эрдэм шинжилгээний хүрээлэн, 2017a; Эдийн засгийн судалгаа эрдэм шинжилгээний хүрээлэн, 2017b; Эдийн засгийн судалгаа эрдэм шинжилгээний хүрээлэн, 2017c; Эдийн засгийн судалгаа эрдэм шинжилгээний хүрээлэн, 2017d)

Хүснэгт Х 1. Гадаадын хөрөнгө оруулалттай Топ-20 компани

#	Компани	Ирэх жил	Нийт хөрөнгө (сая \$)	Гадаадын иргэдийн хувь (%)	Үйл ажиллагаа	Улс орнууд
1	Оюу Толгой	2000	108,5	66	Уул уурхай	Нидерланд, Британийн Виргины арлууд, Монгол
2	Пибоди Рэсурс	2007	61,0	100	Уул уурхай	Нидерланд
3	Чингис хаан банк	2006	32,6	100	Банк	Британийн Виргины арлууд
4	Тефис майнинг	2004	26,9	100	Уул уурхай	Швейцар
5	Болд төмөр ерөө гол	2004	18,9	100	Уул уурхай	Британийн Виргины арлууд
6	Гоёо	2006	18,0	100	Ноолууран эдлэл	Сингапур
7	Хаан банк	2004	20,6	66	Банк	Япон, Хятад, АНУ, Монгол, Хонконг,
8	М-Си-Эс Ази Пасифик брьюэри	2005	23	55	Ус, ундаа	Сингапур, Монгол
9	Арева Монгол	2005	12,5	100	Уул уурхай	Франц
10	Мобиком корпораци	1995	10,7	79	Харилцаа холбоо	Нидерланд, Монгол
11	Улаанбаатар их сургууль	1995	6,7	98	Боловсрол	БНСУ, АНУ, Монгол
12	Вагнер Ази тоног төхөөрөмж	1996	6,4	100	Машин, тоног төхөөрөмж	АНУ
13	Скай резорт	2008	20,9	26	Аялал, жуулчлал	Британийн Виргины арлууд, Монгол
14	Төв Азийн цемент	2003	5,5	98	Барилга	БНХАУ, Хонконг, АНУ, Монгол, Бельги, Сингапур, Нидерланд
15	Монголросцветмет	2007	10,5	49	Уул уурхай	Монгол, Орос
16	Худалдаа Хөгжлийн банк	2002	3,8	80	Банк	Люксембург, Монгол, АНУ
17	Чинхуа МАК Нарийн сухайт	2002	3,6	50	Уул уурхай	БНХАУ, Монгол
18	Үндэсний хөрөнгө оруулалтын банк	2006	3,2	44	Банк	Монгол, Кайманы арлууд, БНХАУ, Хонконг
19	Сүнжин групп	2006	2,3	100	Аялал, жуулчлал	БНСУ
20	Сөүл групп	1996	1,1	95	Үл хөдлөх хөрөнгийн үйлчилгээ	БНСУ, Монгол
Нийт			405,5	79		

Эх сурвалж: Үндэсний хөгжлийн газар

Хүснэгт X 2. Уул уурхайн салбарын бусад салбаруудаас хэрэглэж буй завсрын хэрэглээ, салбараар, 2011

	Эзлэх %
Хөдөө Аж Ахуй	0.20%
Уул уурхай, олборлолт	4.36%
Боловсруулах үйлдвэрлэл	7.67%
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	4.03%
Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент	0.92%
Барилга	9.83%
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклын засвар, үйлчилгээ	20.89%
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	29.15%
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	3.27%
Мэдээлэл, холбоо	1.96%
Санхүү болон даатгалын үйл ажиллагаа	8.60%
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1.13%
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	2.91%
Удирдлага болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	2.29%
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа	1.53%
Боловсрол	0.59%
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	0.40%
Урлаг, үзвэр, тоглоом, наадам	0.10%
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	0.18%

Эх сурвалж: Орц-Гарцын хүснэгт 2011, Үндэсний статистикийн хороо ба судлаачдын тооцоолол

Хүснэгт Х 3. Сингапурын стратегийн үе шат, 1959-с одоо

Стратегийн үе	Гол онцлог
Бие даасан Засгийн газар: Малайзын өмнөх үе (1959-63)	Ардын үйлийн нам (АҮН) нь Анхдагч үйлдвэрлэлийн хуулийг баталснаараа анх үйлдвэржилтийн хөтөлбөрийг эхлүүлсэн. Анхдагч үйлдвэрлэлийн хууль нь ГШХО-ыг татахад хамгийн ач холбогдолтой байсан. Энэ хуулиар шинэ компаниуд дотоодын зах зээл болон экспортын зах зээлд нэвтрэхэд 40%-ын компанийн татвараас чөлөөлөгддөг байсан. Мөн Сингапурын Эдийн засгийн хөгжлийн зөвлөлөөс Сингапурт үйлдвэрүүдийг бүтээн байгуулахад хувийн капиталыг ашиглахыг урамшуулж байсан.
Малайзын үе (1963-65)	Сингапур нь Малайз, Саравак болон Сабах нартай нэгдэж шинэ холбоот улс болох Малайзыг байгуулсан. Үр дүнд нь Сингапур Британиас тусгаар тогтнож чадсан ба илүү том зах зээлд нэвтэрсэн. Харамсалтай нь энэ хугацаанд хамгааллын шинэ тариф тогтоогоогүй боловч хязгаарлалттай (квоттой) бүтээгдэхүүний тоо өсөж 230 бүтээгдэхүүнд хүрсэн.
Импорт орлуулалтын үе (1965-67)	Тусгаар тогтносны дараа (1965 оны 8 сарын 9) бүтээгдэхүүний хязгаарлалт 88-д хүрч буурсан ба засгийн газар дотоодын зах зээлээ хамгаалах зорилго тавьсан. 1965 оны төгсгөл гэхэд 183 бүтээгдэхүүнд хамгаалах татваруудыг ногдуулсан байсан ба 1967 он гэхэд хязгаарлалтын тоо 72-д хүрч буурсан хэдий ч 1969 оны байдлаар 389 бүтээгдэхүүн болж өсжээ.
Экспортод чиглэсэн үе (1967-69)	1967 оны Эдийн засгийг өргөжүүлэх урамшууллын хуулийг баталснаар татварыг багасгаж хүлээн зөвшөөрөгдсөн үйлдвэрлэлүүдийн хувьд татварын хэмжээг 4%-д (40%-аас) хүргэн бууруулсан. Энэ урамшуулал нь 15 хүртэлх жилийн хугацаатай. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, лицензийн төлбөр, гадаадын ААН-д төлөх судалгаа, хөгжүүлэлтийн зардал зэрэг татварыг мөн багасгасан. Сингапурт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд олгосон гадаадын зээлийн хүүг чөлөөлсөн. Гадаадын иргэдийн Сингапурт байршуулсан хадгаламжийн хүүгийн орлогод оногдуулсан татварын хүүг 10%-д хүргэж бууруулсан. Экспортын урамшуулал нь татвараас чөлөөлөх буюу гадаад дах зах зээлд гарах зардлыг татвараас чөлөөлөх замаар бууруулах хэлбэрээр хэрэгжсэн.
Капиталыг ихээр хэрэглэдэг ба Өндөр технологийн үйлдвэрлэлүүдэд чиглэсэн үе (1970-с одоо)	1960 онд Сингапурт олон тооны олон улсын хэмжээний компаниуд аж үйлдвэрлэл болон хуваарилалтын үйлдвэрлэлийг байгуулсан. Эдгээр үйлдвэр нь эцсийн бүтээгдэхүүн, завсрын бүтээгдэхүүн, капиталын тоног төхөөрөмж, эд ангиудыг үйлдвэрлэж толгой болон охин компаниудад нийлүүлдэг байсан. Мөн байгалийн баялаг ашигладаг үйлдвэрлэлүүд болон газрын тосны хайгуул хийдэг компаниудад зориулж химийн бодис үйлдвэрлэдэг байсан. 1971 онд гадаадын үйлдвэрүүд нийт үйлдвэрүүдийн 26% бүрдүүлж, нийт ажил эрхлэгчдийн 63 хувийг ажиллуулж, нийт нэмэгдэл өртгийн 75%, аж үйлдвэрийн экспортын (дахин экспортыг хассан) 75%-ыг бүрдүүлж байжээ. 1970 он гэхэд Сингапур улс нь ерөнхийдөө ажилгүйдлийн асуудлыг бүрэн шийдсэн байсан нь Эдийн засгийн хөгжлийн зөвлөлийн хүчин чармайлтын үр дүн байсан юм. Үр дүнд нь технологи бага шаарддаг, хөдөлмөр ихээр хэрэглэдэг үйлдвэрлэлийг дэмжих эртний бодлого нь олон сонголтод өндөр технологийн үйлдвэрлэлд шилжжээ. Эдийн засгийг өргөжүүлэх урамшууллын хуулийн нэмэлт өөрчлөлт нь (1970) шинэ үйлдвэрлэлүүдийн анхдагч үйл ажиллагааны зөвшөөрөл авахад шаардагдах мөнгөний хэмжээг 1 сая ам.доллар, үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрлэлүүдийн үйл ажиллагаагаа өргөтгөхөд шаардагдах мөнгөний хэмжээг 10 сая ам.долларт хүргэж нэмэгдүүлжээ. Хуучин үйлдвэрлэлүүдийн хувьд 5 жилийн хугацаанд экспортын орлогын өсөлтийн 90 хүртэлх хувьд татвараас чөлөөлөгдөх боломжтой. Шинэ үйлдвэрлэлүүд нь нийт борлуулалтынхаа дор хаяж 20%-ыг экспортолж, экспортын нийт дүнг 100 мянган ам.доллараас давуулж чадсан тохиолдолд татварын хөнгөлөлтийг 10 хүртэлх жил эдлэх боломжтой байсан.
Мэдлэгт суурилсан үйлдвэрүүд ба	Нэхмэл, гутал, тавилга болон угсрах төрлийн энгийн цахилгаан хэрэгсэл зэрэг бага технологи шаардагдах үйлдвэрлэлийн салбарт зүүн болон өмнөд Азийн хөгжиж буй орнууд Сингапуртай өрсөлдөж эхэлсэн. Тэр үед аж

үйлчилгээнд чиглэсэн үе (1980-с одоо)	үйлдвэржсэн орнууд үйлдвэрлэлдээ илүү автоматжуулалт, робот, компьютержүүлэлт гэх мэтийг ашиглах болсон. Шинэ төрлийн үйлдвэрлэл буюу шинжлэх ухаан, технологи, ур чадвар болон мэдлэгт суурилсан 2 дах үйлдвэрлэлийн хувьсгалыг хийхийн тулд эдийн засгийн бүх салбарууд үйлдвэрлэлээ автоматчилж, механикжуулж, компьютержүүлж бас менежментийг сайжруулж, үйлдвэрүүдээ дахин байршуулах хэрэгтэй болсон. Эдийн засгийн хөгжлийн зөвлөлийн зорилго нь аж үйлдвэрлэлийн салбарт өндөр технологийн найдвартай үйлчилгээг нэвтрүүлж, улмаар компьютер, нэгдсэн хэлхээ, тусгай химийн бодис болон төрөл бүрийн аж үйлдвэрийн электрон тоног төхөөрөмжийг үйлдвэрлэхэд оршиж байсан. Мөн боловсролын салбар нь илүү их инженер болон техникийн туслах ажилчдыг бэлтгэх тал дээр ажилласан. Шинэ аж үйлдвэржилтийн бодлого нь Сингапур улсыг хөдөлмөр ихээр ашигладаг үйлдвэрлэлээс шилжихээс гадна эмзэг бус салбарын үйлдвэрлэлийг дэмжих, Сингапур иргэдийн цалинг нэмэгдүүлэхэд чиглэж байсан. Сингапур улс нь нэмэгдэл өртгийн сүлжээнд нэгдсэн.
Өсөлтийн гурвалжин, бүсчлэн хөгжүүлэлт (1986-с одоо)	1984-85 онуудад Сингапур улсад тусгаар тогтносны дараах хамгийн анхны эдийн засгийн хямрал болсон. Эдийн засгийн комисс Сингапурын эдийн засгийн хямрал болон ирээдүйн эдийн засгийн төлөвийг тодорхойлох бодлогын өөрчлөлтүүдийг танилцуулах тайлан гаргасан. Тус тайланд цалингийн хэмжээг 12% бууруулах, зах зээлийн нөхцөлөөс хамаарах уян хатан цалингийн систем, үйлдвэрлэлийн зардлыг бууруулахын тулд засгийн газрын татвар болон хураамжийг бууруулах зэргийг санал болгож байсан. Зүүн өмнөд Азийн орнуудад зардал маш бага байдаг тул олон үндэстэн дамнасан корпорацуудын тоо нэмэгдсэн. Сингапур нь үүнийг боломж, аюул занал гэж үзсэн. Боломж нь үндэстэн дамнасан корпорацуудын бүс нутгийн удирдлагыг улсдаа байршуулбал судалгаа хөгжүүлэлтийн хэрэгсэл, худалдан авалт, маркетинг болон бусад өндөр нэмэгдэл өртөг бүхий үйлчилгээ төвлөрөх боломж бүрдэх байсан. Аюул занал нь Сингапурыг нэмэгдсэн өртгийн сүлжээнд нэгдэхээс өмнө Сингапураас гаралтай үндэстэн дамнасан корпорац нь татан буугдах байсан. Өсөлтийн гурвалжны гол үзэл баримтлал нь энэхүү аюулыг даван туулахын тулд хөгжсөн. Тухайлбал энэ үзэл баримтлал нь Малайз, Индонез зэрэг хөрш улсуудын сонирхлыг ихээхэн татах болсон. Мөн Сингапурын боомт, онгоцны буудал, үйлдвэрлэлийг шахан гаргах өөрсдийн төлөвлөгөөг боловсруулсан. Ерөнхий сайд Сингапурын программ хангамжийг Шазоу аж үйлдвэрийн парк, Вьетнам болон Энэтхэг улс руу экспортлох боломжийг олж авсан. Мөн Засгийн газар нь тухайн бүс нутагт эдийн засаг хурдацтай хөгжих боломж байгааг олж харсан тул төсвийн хөрөнгө оруулалтыг нэмж, хувийн секторын хөрөнгө оруулалтыг дэмжсэн. Газар болон хөдөлмөрийн хомсдолоос болж ДНБ-ын өсөлт саарч байсан нь бүсчлэн хөгжүүлэлтийн өөр нэг чухал шалтгаан байсан.
Стратеги эдийн засгийн төлөвлөгөө (1991-с одоо)	Шинээр сонгогдсон ерөнхий сайдын Сингапурт хийх мөрийн хөтөлбөрт 2 зүйл багтсан: “Дараагийн эрх мэдэл” болон “Стратеги эдийн засгийн төлөвлөгөө”. Түүний зорилго нь Сингапур улсыг 30-40 жилийн дотор баян, хүчирхэг улс болгох буюу иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, хүчирхэг улс орны онцлог шинжтэй болгох болон эдийн засгийн хувьд чөлөөт жинхэнэ олон улсын хот болгох байсан. Эдийн засгийн хувьдах онцгой нэг зорилго байсан нь 2020 он гэхэд Нидерландын, 2030 он гэхэд АНУ-ын нэг хүнд ногдох ҮНО-ыг давах байсан. Үүнийг хийхийн тулд 8 төрлийн стратегийн зорилго тавьсан: • Хүмүүн капиталыг сайжруулах • Үндэсний багийн ажиллагааг дэмжих • Олон улсад илүү чиглэх • Инновацыг дамжуулах уур амьсгалыг бие болгох • Аж үйлдвэрлэл болон үйлчилгээний кластерийг хөгжүүлэх • Эдийн засгийн сэргээн босголтод тэргүүлэх • Олон улсын өрсөлдөх чадварыг хадгалах

	• Эмзэг байдлыг бууруулах Энэхүү төлөвлөгөөгөөр өөрийн ажиллах хүчийг жилд 1.5%-аар өсгөж бүрэн ажил эрхлэлттэй эдийн засгийг бие болгох ба гадаадын ажиллах хүчний өсөлт болон газрын нийлүүлэлтийг хязгаарлаж байсан.
--	--

Эх сурвалж: (Tan, 1999)

Хүснэгт Х 4. Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилт 2030-ын үзүүлэлтүүд

#	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2014 оны суурь түвшин	2030 оны зорилтот түвшин
1	Эдийн засгийн жилийн дундаж өсөлт	%	7.8	6.6 ²⁷
2	Нэг хүнд ногдох үндэсний нийт орлого	Ам.доллар	4,166	17,500
3	Хүний хөгжлийн үзүүлэлт	Эзлэх байр	90	70
4	Дундаж наслалт	Жил	69.57	78
5	Ядуурлын түвшин	%	21.6	0
6	Өрсөлдөх чадварын үзүүлэлт	Эзлэх байр	104	70
7	Бизнес эрхлэлтийн үзүүлэлт	Эзлэх байр	56	40
8	Байгаль орчны багц үзүүлэлт	Эзлэх байр	111	90
9	Эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгалд хамрагдсан байдал	%	21.6	0
10	Орлогын тэгш бус байдлын үзүүлэлт	Оноо	36.5	30
11	1000 амьд төрөлтөд оногдох нялхсын эндэгдлийн түвшин	Харьцаа	15.1	8
12	100000 амьд төрөлтөд оногдох эхийн эндэгдлийн түвшин	Харьцаа	30.6	15
13	Ерөнхий боловсролын сургуулийн анги дүүргэлт (улсын дундаж)	Хүүхдийн тоо	27.3	20
14	Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын хорио цээрийн шаардлагад нийцсэн газар нутгийн эзлэх хэмжээ	%	0	60
15	Цөлжилтөд өртсөн газар нутгийн эзлэх хэмжээ	%	78.2	60
16	Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ	%	17.4	30
17	Монгол Улсад аялах гадаад жуулчдын тоо	Мян.хүн	0.392	2.0
18	Цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангагдсан өрх	%	89	100
19	Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хэмжээ	%	17	50
20	Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээг дотоодын эх үүсвэрээс хангах хувь	%	0	100

Эх үүсвэр: (Монгол Улсын Их хурал, 2016с)

²⁷ 2016-2030 оны дундаж

HOM ЗҮЙ

- Almfraji, M. A., Almsafir, M. K., & Uao, L. (2014). Economic Growth and Foreign Direct Investment Inflows" The Case of Qatar. *Procedia-Social and Behavioural Sciences*, 1040-1045.
- Anand, A. (2011). The impact of Foreign Direct Investment on the sectors: The Case of Mongolia. *Bank of Mongolia: Working Paper-6*, 155-177.
- Anderson, J., & Gonzalez, A. (2012). Does Doing Business matter for foreign direct investment? In W. Bank, *Doing Business 2013* (pp. 47-50). Washington, D.C: World Bank.
- Blomstrom, M., Lipsey, R. E., & Zejan, M. (1992). What Explains Developing Country Growth? *The National Bureau of Economic Research-Working Paper*, 1-36.
- British Geological Survey. (2011). *World Mineral Production 2005-2009*. Nottinghamshire.
- Céspedes, L. F., & Velasco, A. (2012). Macroeconomic Performance During Commodity Price Booms. *IMC Economic Review*, 570-599.
- Cornell University; INSEAD; WIPO. (2017). *Global Innovation Index*. Geneva: WIPO.
- Dixon, W. J., & Boswell, T. (1996). Dependency, Disarticulation, and Denominator Effects: Another Look at Foreign Capital Penetration. *American Journal of Sociology*, 133-151.
- Economic Research Institute. (2017a). *Coal Market Study*. Ulaanbaatar: Admon LLC.
- Economic Research Institute. (2017b). *Copper Market Study*. Ulaanbaatar: Admon LLC.
- Economic Research Institute. (2017c). *Gold Market Study*. Ulaanbaatar: Admon LLC.
- Economic Research Institute. (2017d). *Iron Ore Market Study*. Ulaanbaatar: Admon LLC.
- Fornero, J., Kirchner, M., & Yany, A. (2016). Terms of Trade Shocks and Investment in Commodity-Exporting Economies. *The Central of Chile: Working Paper*, 773-790.
- Fraser Institute. (2016). *Survey of Mining Companies*. Vancouver: Fraser Institute.
- Hansen, H., & Rand, J. (2006). On the Casual Links between FDI and Growth in Developing Countries. *The World Economy*, 21-41.
- Iqbal, M. S., & Shaikh, F. M. (2010). Causality Relationship between Foreign Direct Investment, Trade and Economic Growth in Pakistan. *Asian Social Science*, 82-89.
- Kentor, J., & Boswell, T. (2003). Foreign Capital Dependence and Development: A New Direction. *American Sociological Review*, 301-313.
- Kose, M. A. (2002). Explaining business cycles in small open economies 'How much do world price matter?'. *Journal of International Economics*, 299-327.
- Munkhtsetseg, D., & Gantumur, P. (2015). The optimal policy applying on Foreign Investment. *Bank of Mongolia: Working Paper-10*, 655-724.
- Nnadozie, E. (2011). *Investment Climate and Foreign Direct Investment in Africa*. Ethiopia: African Development Bank Group.
- NRGI. (2015). *Country Strategy Note*. Ulaanbaatar.
- NSO. (2016). *Annual Report*. Ulaanbaatar: NSO.
- OECD. (2008). *The Social Impact of Foreign Direct Investment*. Paris: Policy Brief.
- OSCE. (2006). The importance of a favourable business and investment climate. In OSCE, *The Best-Practice Guide for a Positive Business and Investment Climate* (pp. 16-23). Vienna: Red hot 'n' cool.

- Parliament of Mongolia. (2013). *Investment Law*. Ulaanbaatar: Parliament of Mongolia.
- Parliament of Mongolia. (2016a). *Action Program of The Government of Mongolia for 2016-2020*. Ulaanbaatar: Parliament of Mongolia.
- Parliament of Mongolia. (2016b). *The Budget of 2017*. Ulaanbaatar: Parliament of Mongolia.
- Parliament of Mongolia. (2016c). *The Mongolian Sustainable Development Vision-2030*. Ulaanbaatar: Parliament of Mongolia.
- Parliament of Mongolia. (2017). *The Amendment of the Budget of 2017*. Ulaanbaatar: Parliament of Mongolia.
- Quazi, R. M., & View, P. (2007). Investment climate and foreign direct investment: A study of selected countries in Latin America. *Global Journal of Business Research*, 1-13.
- Skousen, M. (1996, July 1). *Economics and Poverty*. Retrieved from Foundation for Economic Education: <https://fee.org/articles/how-real-is-the-asian-economic-miracle/>
- Tan, A. H. (1999). Official Efforts To Attract FDI: Case of Singapore's EDB. *Conference on Industrial Globalization in the 21st Century: Impact and Consequences for East Asia and Korea* (pp. 1-22). Seoul: Korean Development Institute, East-West Center.
- The Economist Intelligence Unit. (2014). *Business Environment Rankings: Which country is best to do business in?* London: The Economist Intelligence Unit.
- The Mongolian Mining Journal. (2017, June 1). The Mongolian Mining Journal. *Monpolimet Group: Mining sector with social respnsobility for 25 years*, pp. 46-47.
- U.S. Department of State. (2014). *Investment Climate Statement: Case of Switzerland*. Washington, D.C: U.S. Department of State.
- UNCTAD. (2016). *World Investment Report*. Geneva: United Nations Publication.
- UNCTAD. (2017). *World Investment Report*. Geneva: United Nations Publication.
- World Bank. (2017a). *Doing Business: Equal Oppotunity for All*. Washington, D.C: Corporate Vision. Inc.
- World Bank. (2017b). *Commodity Market Outlook*. Washington, DC: World Bank.